



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ,
ШИЙДВЭР, ХУУЛИЙН ТАЙЛБАР

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

1996 оны 10-р сар

№ 10 /53/

ГАРЧИГ

1. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Гэр бүлийн хуульд өөрчлөлт оруулах тухай	601
Монгол Улсын Хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	605
Гэрээ соёрхон батлах тухай	606
Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	606
Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай	607
Захиргааны хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	607
Хуулийн зарим бүлгийг хүчингүй болсонд тооцох тухай	608
Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай	608
Конвенци соёрхон батлах тухай	609
Хэлэлцээр соёрхон батлах тухай	609
Конвенци соёрхон батлах тухай	610
Конвенци соёрхон батлах тухай	610
Монголын тулгар төрийг үүсгэн байгуулсны 790 жилийн ойг тохиолдуулан насанд хүрээгүй эгтээд, эмэгтэйчүүд, жар, түүнээс дээш насны эрэгтэйчүүдэд өршөөл үзүүлэх тухай	611
Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	612
Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай	615

2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | |
|--|---|
| 16. Төрөөс хөдөөгийн талаар баритлах бодлогын үндсэн чигэлийг батлах тухай №32 | 6 |
| 17. Улсын төвлөрсөн төсвийн 1995 оны гүйцэтгэлийг батлах тухай №33 | 6 |
| 18. Монголбанкны жилийн тайлан тэнцэл, ашгийн хуваарилалтыг батлах тухай №34 | 6 |
| 19. Төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийг хэлэлцсэн тухай №35 | 6 |
| 20. Санал шүүмжлэлийн мөрөөр зохиох ажлын тухай №36 | 6 |
| 21. Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн тухай №37 | 6 |
| 22. Засгийн газрын гишүүн байсан зарим хүмүүсийн хангамжийн тухай №27 | 6 |
| 23. Комисс байгуулах тухай №28 | 6 |
| 24. "Залуучуудын өдөр" бий болгох тухай №29 | 6 |
| 25. Ажилд томилох тухай №31 | 6 |
| 26. Хэлмэгдэгчдийн дурсгалын өдөр бий болгох тухай №33 | 6 |

3. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | |
|--|---|
| 27. Б.Цэдэвт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол олгох тухай №148 | 6 |
| 28. Г. Чадраабалд Монгол Улсын гавьяат мал зүйч цол олгох тухай №149 | 6 |
| 29. Д. Мятагт Монгол Улсын гавьяат багш цол олгох тухай №150 | 6 |
| 30. Р. Оюунбадамд Монгол Улсын гавьяат хуульч цол олгох тухай №151 | 6 |
| 31. Ж. Биндэрьяад Монгол Улсын гавьяат эмч цол олгох тухай №152 | 6 |
| 32. С. Вандан, Д. Дуламсүрэн нарт Монгол Улсын гавьяат жүжигчин цол олгох тухай №153 | 6 |

4. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ

- | | |
|--|---|
| 33. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай №02 | 6 |
|--|---|

5. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | |
|---|-----|
| 1. Стандарт, чанар, хэмжилзүйн улсын хяналтын
дүрэм батлах тухай №57 | 658 |
| 2. Журам батлах тухай №62 | 670 |

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 5 дугаар
сарын 9-ний өдөр

Улаанбаатар
хот

ГЭР БҮЛИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гэр бүлийн хуулийн 41,48,51 дүгээр зүйлийг дор
дсанаар өөрчлөн найруулсугай:

41 дүгээр зүйл. Хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх эцэг,
эхийн үүрэг

1.Эцэг, эх хүүхдээ асран хамгаалж, тэжээн тэтгэж, өсгөн
мүүжүүлэх үүрэгтэй.

2.Эцэг, эх гэрлэлтээ цуцлуулсан тохиолдолд энэ зүйлийн 1 дэх
зэгт заасан үүрэг нь хэвээр үлдэнэ. Хүүхдийн эрх, хууль ёсны
инг сонирхолд харшлахааргүй бол гэрлэлтээ цуцлуулсан эцэг,
ийн аль нэг нь нөгөөдөө энэ үүргээ хэрэгжүүлэхэд саад
руулахыг хориглоно.

3.Эцэг, эхийн аль нэг нь нас барсан, эцэг, эх байх эрхээ
зуулсан бол нөгөө нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргийг
гээнэ.

48 дугаар зүйл. Хүүхэд үрчлэх, үрчлүүлэх

1.Хүүхэд үрчлэх, үрчлүүлэх асуудлыг сум, дүүргийн Засаг дарга
ялдвэрлэнэ. Хүүхэд үрчилснийг бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

2.Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэн, харьяалалгүй
эд үрчлүүлэхийг хориглоно.

51 дүгээр зүйл. Хүүхэд үрчлэх, үрчлүүлэх нөхцөл

1.Хүүхдийн эцэг, эх хүүхдээ үрчлүүлэх зөвшөөрөл болон хүүхэд
илэхийг хүсэгч өөрийн хүсэлтээ бичгээр гаргана.

2.Бүтэн өнчин хүүхэд, түүнчлэн эцэг, эх нь хоёулаа эрхийн
үн чадамжгүй гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ
зуулсан хүний хүүхдийг үрчлүүлэх тохиолдолд хуульд өөрөөр
гаагүй бол тухайн хүүхдийн асран хамгаалагч, харгалзан
ажигчийн зөвшөөрлийг авна.

3.Есөн нас хүрсэн хүүхдийг үрчлэх, үрчлүүлэх асуудлыг уг
хдийн өөрийнх нь саналын дагуу шийдвэрлэнэ.

2 дугаар зүйл. Гэр бүлийн хуулийн аравдугаар бүлгийг дор
дсанаар өөрчлөн найруулсугай:

"АРАВДУГААР БҮЛЭГ

АСРАН ХАМГААЛАХ, ХАРГАЛЗАН ДЭМЖИХ

76 дугаар зүйл. Асран хамгаалбал зохих хүн

Дараахь хүнийг асран хамгаална:

1/бага насны бүтэн өвчин хүүхэд;

2/эцэг, эх нь хоёулаа эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсн болон эцэг, эх байх эрхээ хасуулсан хүний бага насны хүүхэд;

3/эцэг, эх нь хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүү хорих газарт ял эдэлж байгаа зэрэг аргагүй шалтгаанаар хүүх биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй хүний б насны хүүхэд;

4/сэтгэцийн өвчний улмаас шүүхээс эрхийн бүрэн чадамж гэж тооцогдсон хүн.

77 дугаар зүйл.Харгалзан дэмжвэл зохих хүн

Дараахь хүнийг харгалзан дэмжинэ:

1/насанд хүрээгүй бүтэн өвчин хүүхэд;

2/эцэг, эх нь хоёулаа эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогд болон эцэг, эх байх эрхээ хасуулсан хүний насанд хүрээгүй хүүхэд.

3/эцэг, эх нь хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүү хорих газарт ял эдэлж байгаа зэрэг аргагүй шалтгаанаар хүүх биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй хүний нас хүрээгүй хүүхэд;

4/согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэсн улмаас эрхийн хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон хүн;

5/эрүүл мэндийн болон өндөр настай болсны улмаас иргэн эрх үүргээ бие даан хэрэгжүүлэх бололцоогүй болсон хүн.

78 дугаар зүйл. Асран хамгаалах, харгалзан дэмжих

байгууллага

1.Энэ хуулийн 76, 77 дугаар зүйлд заасан хүнийг судлан тогтн тэднийг хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй бол асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаатай холбоо бусад асуудлыг шийдвэрлэх чиг үүргийг сум, дүүргийн Засаг д хэрэгжүүднэ.

2.Хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоогдос хүүхдийг хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллага, асран хамгаал зохих насанд хүрсэн хүнийг нийгмийн халамжийн байгууллага ас хамгаалж, харгалзан дэмжих ажлыг эрхэлнэ.

79 дүгээр зүйл.Асран хамгаалах, харгалзан дэмжих журам

1.Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг дор дурдсан журм тогтооно:

1/эд хөрөнгийн зохих бололцоотой төрөл сэднм болон төрөл нм бус хүний бичгээр гаргасан зөвшөөрлийг нь үндэслэн асран игаалагч, харгалзан дэмжигчээр шүүх тогтооно.

2/хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоогдоогүй т хүүхдийг нас, эрүүл мэндийн байдлыг нь харгалзан хүүхэд асран гүүжүүлэх байгууллагад шилжүүлж болно.

3/хууль ёсны харгалзан дэмжигч тогтоогдоогүй бол өндөр настан, ир дутуу хүнийг асрамжийн газарт шилжүүлж болно;

4/сэтгэцийн өвчний улмаас эрхийн бүрэн чадамжгүй гэж ицогдсон, бусад шалтгаанаар эрхийн чадамжаа хязгаарлуулсан нийг эмнэлэгт шилжүүлж болно.

2.Тухайн хүн асран хамгаалуулах, харгалзан дэмжүүлэх шаард татай байгаа тухай мэдээллийг аливаа байгууллага, иргэн холбог : сум, дүүргийн Засаг даргад өгөх үүрэгтэй.

3.Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэн, Монгол Ул байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг асран игаалж, харгалзан дэмжихэд энэ хуулийг дагаж мөрдөнө. Гадаад ад оршин суугаа Монгол Улсын иргэнд тухайн улсын хуулиар ан хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосныг хүчинтэйд тооцно.

4.Асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагааны журмыг гийн газар батална.

80 дугаар зүйл. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр томилж болохгүй хүн

Дор дурдсан хүнийг асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр илохыг хориглоно:

1/эцэг, эх байх эрхээ хасуулсан;

2/өөрөө асран хамгаалуулж, харгалзан дэмжүүлж байгаа;

3/мансууруулах буюу согтууруулах ундаа байнга хэрэглэгч этгээд;

4/хорих ял эдэлж байгаа этгээд.

81 дүгээр зүйл. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг

Асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь дараахь үүрэг хүлээнэ:

1/асрамж, дэмжлэгтээ байгаа хүнийг хоол хүнс, орон байраар гах, асран сувилах;

2/асрамж, дэмжлэгтээ байгаа хүний эрх, ашиг сонирхлыг гаалах;

3/асрамж, дэмжлэгтээ байгаа хүний үл хөдлөх хөрөнгө, мал, гөн халгаламж, бусад үнэт зүйлийг захиран зарцуулахдаа сум, гийн Засаг даргаас зөвшөөрөл авч байх;

4/гүйцэтгэж байгаа үүргийнхээ талаар орон нутгийн Засаг даргад : бүр тайлагнах.

82 дугаар зүйл. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хориглох зүйл

Асран хамгаалагч, харгалзан дэмжигчид дараахь үйлдэл хийхи хориглоно:

1/асрамж, дэмжлэгтээ байгаа хүнтэй хэлцэл хийх;

2/асрамж, дэмжлэгтээ байгаа хүний нэрийн өмнөөс өөрийн г бүл, төрөл садантай хэлцэл хийх;

3/асрамж, дэмжлэгтээ байгаа хүн болон өөрийнхөө гэр бүл төрөл садны хооронд үүссэн маргааныг шүүхээр шийдвэрлэхэд хүнийг төлөөлөх;

4/асрамж, дэмжлэгтээ байгаа хүний нэрийн өмнөөс бэлэглэли гэрээ хийх;

5/асрамж, дэмжлэгтээ байгаа хүний үл хөдлөх хөрөнгө, мөнгөн хадгаламж, бусад үнэт зүйлийг өөрт нь зориулахаас бус тохиолдолд худалдах, арилжих, барьцаалах, дэнчин тавих, завш санаатайгаар үрэгдүүлэх, ашиглан шамшигдуулах.

83 дугаар зүйл. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үйл ажиллагаанд хяналт тавих

1. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үйл ажиллагаанд сү дүүргийн Засаг дарга хяналт тавина.

2. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үйл ажиллагаат холбогдуулан байгууллага, иргэн, сум, дүүргийн Засаг даргад гомс гаргах, мэдээлэл өгөх эрхтэй.

84 дүгээр зүйл. Асран хамгаалах, харгалзан дэмжих үүргээс чөлөөлөх

1. Дараахь тохиолдолд асран хамгаалах, харгалзан дэмжих үүрг чөлөөлнө:

1/хүүхдийг эцэг эхэд нь буцаасан, үрчлүүлсэн, асрамжийн газ шилжүүлсэн;

2/харгалзан дэмжүүлэгч хүсэлт гаргасан;

3/асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан.

2. Асран хамгаалагч, харгалзан дэмжигч эрхээ урвуулан ашиг сан, үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол шүүх асран хамгаали харгалзан дэмжигчээр тогтоосон шийдвэрээ хүчингүй болгож, ас хамгаалагч, харгалзан дэмжигч шинээр тогтооно.

85 дугаар зүйл. Асран хамгаалах, харгалзан дэмжих эрх, үүрэг дуусгавар болох

1. Асран хамгаалуулж байгаа хүүхэд 14 насанд хүрмэгц түүний ран хамгаалагч нь харгалзан дэмжигчийн эрх эдэлж, үүрэг хүлээн;

2. Дараахь тохиолдолд асран хамгаалах, харгалзан дэмжих э үүрэг дуусгавар болно:

1/харгалзан дэмжүүлэгч хүүхэд 18 насанд хүрсэн;

2/энэ хуулийн 76 дугаар зүйлийн 3, 77 дугаар зүйлийн 3 д заалтад заасан нөхцөл арилсан;

3/шүүхийн шийдвэрээр харгалзан дэмжүүлэгчийг эрхийн бүрэн дамжтай гэж тооцсон, эрхийн чадамжийг нь хязгаарласан нөхцөл илсан;

4/харгалзан дэмжигч, дэмжүүлэгчийн аль нэг нь нас барсан.

3.Асран хамгаалах, харгалзан дэмжих үүргээс чөлөөлөгдсөн уг х, үүрэг дуусгавар болсон тохиолдолд асран хамгаалагч, харгалзан мжигч нь асрамж, дэмжлэгтээ байсан хүний эд хөрөнгийн талаарх ялан, тооцоог 3 сарын дотор орон нутгийн Засаг даргад гаргаж нө.

4. Асран хамгаалах, харгалзан дэмжих үүргээс чөлөөлөгдсөн, уг х, үүрэг дуусгавар болсон тохиолдолд асран хамгаалагч, харгалзан мжигч нь асрамж, дэмжлэгтээ байсан хүний эд хөрөнгийн түүнд рт нь буюу хууль ёсны төлөөлөгч, өв залгамжлагчид шилжүүлж тө."

3 дугаар зүйл. Гэр бүлийн хуулийн 86, 87, 88, 89, 90 дүгээр илийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 1996 оны 6 дугаар сарын 1-ний рөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 5 дугаар
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Хилийн тухай хуулийн 33 дугаар илийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 13 дугаар зүйл асүгэй:

"13/Улсын хилийн боомтгүй буюу зөвшөөрөгдөөгүй газраар маа, тээврийн хэрэгслийг хил нэвтрүүлсэн, эсхүл хил нэвтрүү-зийг завдсан бол уул бараа, тээврийн хэрэгслийг хураан авч ын орлого болгох, хураах боломжгүй тохиолдолд тэдгээрийн ийг гэм буруутай этгээдээс гаргуулж улсын орлого болгох."

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 5 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1995 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр Улаанбаат хотноо байгуулсан "Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улс хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны Гэрээ" соёрхон баталсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 5 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаат
хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйл 4, 5 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

28 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

4. Улс төрийн болон тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагч /сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, зэвсэгт хүчин, буцэрэг, тагнуул, цагдаа, хорих байгууллагын тусгай албан тушаал бусад/-ийн албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно.

28 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

5. Дор дурдсан төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, жишгийг Засгийн газар тогтооно.

1/сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга;

2/төрийн захиргааны албан хаагчид;

3/зэвсэгт хүчин, бусад цэрэг, тагнуул, цагдаа, хорих байгууллаг тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид;

4/үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 5 дугаар
сарын 27-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 185 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/185 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1.Ой, хээрийн түймэр санаатай тавьсан нь энэ хуулийн 64, 134 гээр зүйлд заасан гэмт хэргийн шинжгүй бол дөрвөн жил хүртэл гацаагаар хорих буюу тавин мянгаас хоёр зуун мянга хүртэл грөгөөр торгох ял шийтгэнэ."

2/186 дугаар зүйл:

"186 дугаар зүйл. Ой, хээрийн түймэр болгоомжгүй тавих

Гал болон орчиндоо аюул учруулж болох зүйлтэй болгоомжгүй рьцсаны улмаас түймэр алдаж, ой, бэлчээр утсан буюу үлэмж мжээтэй гэмтсэн, хүний амь хохирсон, эсхүл өөр хүнд хор уршиг ирсан бол долоон жил хүртэл хутацаагаар хорих буюу нэг зуун нгаас таван зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ."

2 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 185 дугаар зүйлийн 2 дахь зүйлийн "хоёроос арван жил хүртэл" гэснийг "таваас арван таван л хүртэл" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 1996 оны 6 дугаар сарын 1-ний эвс дагаж мөрдөнө.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг буцаан хэрэглэхгүй.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 5 дугаар
сарын 27-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 25¹ дүгээр лийн "500-25000 төгрөгөөр" гэснийг "зөрчил гаргасан иргэнийг

1000-50000 төгрөгөөр, албан тушаалтныг 30000-60000 төгрөгөөр байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-250000 төгрөгөөр” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1996 оны 6 дугаар сарын 1-ни өдрөөс дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Энэ хуулийг буцаан хэрэглэхгүй.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 5 дугаар
сарын 27-ны өдөр

Улаанбаатаг
хот

ХУУЛИЙН ЗАРИМ БҮЛГИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль батлагдсантай холбогдуулан 1991 онд батлагдсан Аж ахуйн нэгжийн тухай хуулийн “Улсын үйлдвэрийн газар” гэсэн тавдугаар бүлгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 5 дугаар
сарын 27-ны өдөр

Улаанбаатаг
хот

ХУУЛИЙН ЗҮЙЛ, ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Нөхөрлөл, компанийн тухай хуулийн дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 86 дугаар зүйлийг тус тус хүчинг болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Нөхөрлөл, компанийн тухай хуулийн есдүгээр лгийн гарчгаас "төрийн өмчийн болон", 85 дугаар зүйлийн эцгээс "төрийн болон" гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн сай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 8 дугаар
сарын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

КОНВЕНЦИ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1996 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр Парис ноо гарын үсэг зурсан "Орлого ба хөрөнгийн татварыг хардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас дчилан сэргийлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд йрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын конвенци"-ийг ийн газрын өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 8 дугаар
сарын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1996 оны 5 дугаар сарын 9-ний өдөр Улаанбаатар ноо гарын үсэг зурсан "Орлогын татварыг давхардуулж дуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан гийлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах иалист Вьетнам Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр"- Засгийн газрын өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 8 дугаар
сарын 22-ны өдөр

Улаанбаат
хот

КОНВЕНЦИ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1996 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Пап хотноо гарын үсэг зурсан "Ган, цөлжилтөд ноцтой нэрвэгдэж, орнуудын цөлжилт ялангуяа африкийн цөлжилттэй тэмцэх тус Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенци"-ийг соёргох баталсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 8 дугаар
сарын 22-ны өдөр

Улаанбаат
хот

КОНВЕНЦИ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1996 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр Лондон хотноо гарын үсэг зурсан "Орлого ба хөрөнгийн татвар давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдал урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Британи, Умарт Ирландын Нэгдсэн Вант Улсын Засгийн газар хоорондын конвенци"-ийг Засгийн газрын өргөн мэдүүлсний дүрээр соёргох баталсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 8 дугаар
сарын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛЫН ТУЛГАР ТӨРИЙГ ҮҮСГЭН БАЙГУУЛСНЫ 790 ЖИЛИЙН ОЙГ ТОХИОЛДУУЛАН НАСАНД ХҮРЭЭГҮЙ ЭТГЭЭД, ЭМЭГТЭЙЧҮҮД, ЖАР, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ЭРЭГТЭЙЧҮҮДЭД ӨРШӨӨЛ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гэмт хэрэг үйлдэж анх удаа хорих ял шийтгүүлсэн эр дурдсан хоригдлагыг тэдэнд шүүхээс оногдуулсан ялын хугацааг иргэлзахгүйгээр эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялаас өршөөн хэлтрүүлнэ:

1/арван зургаан насанд хүрээгүй байхдаа үйлдсэн гэмт хэрэгт ял тэлж байгаа;

2/арван дөрвөн насанд хүрээгүй гурав ба түүнээс дээш хүүхэдтэй, үнчлэн гурав хүртэлх насны хүүхэдтэй буюу жирэмсэн эгтэйчүүд;

3/өөрийн шууд асрамжинд байгаа арван зургаа хүртэлх насны нас өнчин хүүхэдтэй буюу өрх толгойлсон эмэгтэйчүүд;

4/арван найман насанд хүрээгүй этгээд, тавин тав, түүнээс дээш насны эмэгтэйчүүд, жар, түүнээс дээш насны эрэгтэйчүүд;

5/ял эдэлж байхдаа бие махбодно санаатайгаар гэмтээснээс бусад алтаанаар тахир дутуугийн нэг, хоёрдугаар зэрэгт орсон насанд хүрээгүй этгээд, эмэгтэйчүүд, жар, түүнээс дээш насны эрэгтэйчүүд.

2 дугаар зүйл. Хорихоос өөр төрлийн хөнгөн ял шийтгүүлсэн, үнчлэн гэмт хэрэг болгоомжгүй үйлдэж таван жилээс дээшгүй, мт хэрэг санаатай үйлдэж гурван жилээс дээшгүй хугацаагаар рих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй этгээд, эмэгтэйчүүд, жар, үнээс дээш насны эрэгтэйчүүдийг эдлээгүй үлдсэн үндсэн болон мэгдэл ялаас тус тус өршөөн хэлтрүүлнэ.

3 дугаар зүйл. Гэмт хэрэг болгоомжгүй үйлдэж таван жилээс эш хугацаагаар, гэмт хэрэг санаатай үйлдэж гурван жилээс дээш гацаагаар хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй этгээд, гтэйчүүд, жар, түүнээс дээш насны эрэгтэйчүүд эдэлбэл зохих ын талаас доошгүйг эдэлсэн бол үлдсэн ялаас нь өршөөн лтрүүлэх буюу талаас доошгүйг эдлээгүй бол үлдсэн ялаас хоёр тлийг өршөөн хасна.

4 дүгээр зүйл. Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө ял алж дууссан бөгөөд Монгол Улсын Эрүүгийн хуулийн 54 дүгээр жилийн 1 дэх хэсгийн /д/, /е/, /ж/-д заасан ял шийтгэлгүй болох

хугацаа, түүнчлэн ял тэнсэгдсэн, хорих газраас тэнсэн суллагдсан этгээдийн хянан харгалзах, насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанаас үлдсэнийг тус тус хэрэгсэхгүй болгоно.

5 дугаар зүйл. Дор дурдсан этгээдийг энэ хуульд заасан өршөөд үл хамааруулна:

1/цаазаар авах ял шийтгүүлсэн, уг ял нь уучлагдан хорих ялаа солигдсон;

2/онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон, гурав, түүнээс дээг удаа ял шийтгүүлсэн;

3/Монгол ардын хувьсгалын 70 жилийн ойг тохиолдуула өршөөл үзүүлэх тухай БНМАУ-ын 1991 оны 6 дугаар сарын 21-ны өдрийн хуулиар өршөөгдсөн болон түүнээс хойшхи хугацаан зарлигаар уучлагдан хорих ялаас чөлөөлөгдсөний дараа гэмт хэрэ санаатай үйлдсэн;

4/төрийн эсрэг онц аюултай гэмт хэрэг /Монгол улсын Эрүүгийн хуулийн 60-68 дугаар зүйл/; зандалчлах /Эрүүгийн хуулийн 7 дугаар зүйл/; бусдыг санаатай алах /Эрүүгийн хуулийн 36 дугаа зүйл/; хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын бие махбодид хүн гэмтэл учруулах /Эрүүгийн хуулийн 90 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг хүчиндэх /Эрүүгийн хуулийн 112 дугаар зүйл/; хүндрүүлэх нөхцө байдалтайгаар бусдын эд хөрөнгийг дээрэмдэх /Эрүүгийн хуулийн 125 дугаар зүйлийн 2 дахь хэсэг/.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 1996 оны 8 дугаар сарын 26-н өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

7 дугаар зүйл. Энэ хууль 1996 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 13.00 цагаас өмнө гэмт хэрэг үйлдсэн хүмүүст хамаарна.

Монгол Улсын Их Хурлын дарга

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 8 дугаар сарын 27-ны өдөр

Улаанбаатга хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн

нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн нэр, мөн зүйлийн 2 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 3 дахь доголыг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

1/9 дүгээр зүйлийн нэр:

"9 дүгээр зүйл. Хурал, түүний бүрэн эрхийн хутагаа"

2/9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийн хутагаа 4 жил байна."

3/ 23 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 3 дахь догол:

"Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нар эрэн тооны байна. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга тухайн Хурлын төлөөлөгч байж болно."

2 дугаар зүйл. "Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-д дор дурдсан агуулгатай эсэг, зүйл нэмсүгэй:

1/9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид ажлын албатай байж болно."

2/ 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

"3.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн бүрэн эрхийн хутагаа тухайн Хурлын шинээр сонгогдсон төлөөлөгчдийн үрэн эрхийг хүдээн зөвшөөрснөөр дуусгавар болно."

3/ 9 дүгээр зүйл:

"9¹ дүгээр зүйл. Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тоо

Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тоог хүн амын айршил, засаг захиргааны нэгжийн бүтцийг харгалзан дор үрдсанаар тогтооно:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:

1/50000 хүртэл хүн амтай бол 25;

2/50000-90000 хүртэл хүн амтай бол 30;

3/90000-аас дээш хүн амтай бол 35.

2.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал-40

3.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:

1/ 2000 хүртэл хүн амтай бол 15;

2/ 2000-9000 хүртэл хүн амтай бол 20;

3/ 9000-аас дээш хүн амтай бол 25.

4. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:

1/Багануур, Багахангай, Налайх 15;

2/бусад дүүрэгт 35."

4/ 12¹ дүгээр зүйл:

"12¹ дүгээр зүйл: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн даргыг сонгох

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн даргыг сонгохдоо Улсын Их Хурлын тухай хуулийн
23 дугаар зүйлийн 2,3,4 дэх хэсэгт заасан журмыг үндэс болгоно."

5/ 12² дугаар зүйл:

"12² дугаар зүйл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч-
дийн даргын нийтлэг бүрэн эрх

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн дарга нь дараахь нийтлэг бүрэн эрхийн
хэрэгжүүлнэ:

1/тухайн Хурлын ээлжит болон ээлжит бус хуралдааныг товлон
зарлах, бэлтгэл ажлыг нь хангуулах асуудлыг хариуцаж Тэргүү-
лэгчдийн хуралдаанд оруулах;

2/тухайн Хурлын хуралдааныг даргалж, хэлэлцсэн асуудлаа
шийдвэр гаргуулах;

3/Хурлын Тэргүүлэгчид, төлөөлөгчдийн бүрэн эрхээ хэрэгжүү-
лэхэд нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

4/Хурал, түүний Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэх асуудлыг хүлээ
авах, тэдгээрийг боловсруулах, шийдвэрлэх ажлыг зохион байгуулах

5/Хурлын шийдвэрийн биелэлтийг хянан шалгах ажлыг зохио
байгуулах;

6/аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүү-
лэгчдийн нарийн бичгийн даргыг Тэргүүлэгчдийн хуралдаан
оруулж томилуулах;

7/сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч-
дийн нарийн бичгийн даргыг Тэргүүлэгчдийн хуралдаанаар сонго
батлуулах;

8/тухайн шатны Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх,
чөлөөлүүлэх, огцруулах саналыг Хуралд оруулах;

9/нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж
ажлыг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавих;

10/тухайн орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуу-
лалтад хяналт тавих;

11/Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгууль, тухайн
шатны Хурлын сонгууль явуулах ажлыг нутаг дэвсгэрийнхн
хэмжээнд зохион байгуулах;

12/хуулийн төсөл, төр, нийгмийн чухал асуудлыг ард нийтээ
хэлэлцүүлэх, санал асуулга явуулах ажлыг нутаг дэвсгэрийнхн
хэмжээнд зохион байгуулах;

13/тухайн шатны Засаг даргын хөтөлбөр, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн жилийн зорилтын биелэлтэд хяналт тавьж, ангуулах арга хэмжээ авах;

14/харьяа нутаг дэвсгэр дэх нам, олон нийт, шашны айгууллагуудтай харилцах;

15/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тавьсан санал, өргөдөл, эмдлыг барагдуулах ажлыг зохион байгуулах;

16/сум, дүүргийн Хурлын байгууллагад мэргэжил, арга зүйн үзлалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах;

17/тухайн Хурлыг дотоод гадаад харилцаанд төлөөлөх;

18/төрийн дээд шагналаар шагнуулах, уучлал үзүүлэх асуудлыг эргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн, зохих дээд байгууллагад тэмжлэх;

19/тухайн шатныхан хуралд жилд 1-ээс доошгүй удаа ажлаа ийлагнах;

20/хуулиар олгогдсон бусад бүрэн эрх."

3 дугаар зүйл. "Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 9 дүгээр зүйлийн 3, 4 х хэсэг, 11, 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, 13 дугаар зүйлийн дахь хэсгийн "Сум, дүүргийн Хурлын төлөөлөгч сонгох," гэснийг олон 28 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, "Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өрчлөлт оруулах тухай" 1994 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн онгол Улсын хуулийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга

Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1996 оны 8 дугаар
сарын 27-ны өдөр

Улаанбаатар
хот

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлын сонгууль /цаашид "сонгууль" гэх/ - ийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Сонгуулийн тухай хууль тогтоомж

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хура /цаашид "иргэдийн Төлөөлөгчдийн Хурал" гэх/-ын сонгуулийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Улсын Их Хурлын сонгуулийн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, энэ хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Сонгуулийн үндсэн зарчим, хутагаа

1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль Монгол Улсын иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхтэй оролцож санала нууцаар гаргах зарчимд үндэслэнэ.

2. Санал авах өдөр аймаг, нийслэл, сум, дүүргийн нутаг дэвсгэр байнга оршин сууж байгаа Монгол Улсын 18 насанд хүрсэн сонгуулийн эрх бүхий иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, алба тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол ялгаваргүйгээ сонгох эрхтэй. Гагцхүү эмнэлгийн дүгнэлт, шүүхийн шийдвэрээ ухаан солиотой нь нотлогдсон, түүнчлэн хорих газар ял эдэлж байгаа хүн сонгуульд оролцохгүй.

4 дүгээр зүйл. Сонгуулийн үйл ажиллагааны эдийн засгийн баталгаа

1. Сонгууль зохион байгуулж явуулахтай холбогдсон дор дурдсан зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ:

1/нэр дэвшигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтны болон ажиглагчийн үнэмлэх, саналын хуудас, сонгуулийн дүн, мэдээний маягт хэвлэх, шаардлагатай бол сонгуулийн хороодын тамга, тэмдэг хийлгэх зардал;

2/сонгуулийн хороодын бичиг хэрэг, шуудан, холбоо, унаа, алба томилолтын зардал;

3/Улсын Их Хурлаас тогтоосон бусад зардал.

2. Улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг Улсын Их Хурал тогтооно.

3. Сонгуулийн хорооны гишүүний тус хороонд ажилласан хөл сонгуулийн хороодын ажиллах, санал авах байр, сонгуулийн хороодыг тээвэр, холбооны болон бусад шаардлагатай хэрэгслэл хангах асуудлыг Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн хуулийн дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасны дагуу зохицуулна.

4. Нам, эвслээс болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн зардлаа Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 5 дугаар

йлийн 6 дахь хэсэгт заасны дагуу хариуцна.

5. Нам, эвслийн салбар байгууллага болон бие даан нэр дэвшигч, сонгуулийн зардлын сан байгуулж тухайн засаг захиргаа, нутаг өсгөрийн нэгж дэх банк, банкны салбарт данс нээж аймаг, йслэл, сум, дүүргийн сонгуулийн хороонд мэдэгдэж нийтэд рлана. Энэ дансанд тухайн нам, эвслийн салбар байгууллага болон бие даан нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө, талархан дэмжигч аж уйн нэгж, байгууллага, иргэдээс оруулсан хандивыг төвлөрүүлж, эн дансаар дамжуулан зарцуулна.

6. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага сонгуульд зориулж зөвхөн өнгөн хандив өргөж болох бөгөөд түүнийг сонгуулийн зардлын нгийн дансанд оруулна. Уг данснаас гадуур сонгуульд зориулж хандив авах, өгөх, зарцуулах, түүнчлэн төсөвт ба төрийн өмч олцсон байгууллага /төрийн өмчийн хэсгээс нь/, гадаадын аж уйн нэгж, байгууллага /хамтарсан байгууллагын гадаадын олцогч/, иргэн харьяалалгүй хүнээс сонгууль бэлтгэн явуулах энгууль зарласнаас эхлээд дуустал/ хугацаанд хандив авч үл лно.

7. Сонгууль бэлтгэн явуулах хугацаанд аливаа тусламжийн эд рөнгийг борлуулж сонгуульд зарцуулахыг хориглоно.

8. Нам, эвслийн салбар байгууллагын болон бие даан нэр шигчийн сонгуулийн зардлын дансны хөдөлгөөнийг зогсоох, сонгуулийн зардлын санг зарцуулах асуудлыг Монгол Улсын Их рлын Сонгуулийн хуулийн 5 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсэгт заасны дагуу зохицуулна.

9. Сонгуулийн зардлын сан бий болгох, зарцуулах, тайлагнах аргыг Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хороо тлна.

10. Нам, эвслийн салбар байгууллага, бие даан нэр дэвшигч нь сонгуулийн зардлын сангийн зарцуулалтын тайланг дансны төлгөөн зогсоосон өдрөөс хойш хагас сарын дотор аймаг, йслэл, сум, дүүргийн сонгуулийн хороонд хүргүүлд. Сонгуулийн юуд уг тайланг хянан хэлэлцэж, сонгууль дууссан өдрөөс хойш сарын дотор дүнг орон нутгийн хэвлэлд нийтэлнэ.

11. Сонгуулийн зардлын сангаас зориулалтын бусаар зарцуулсан өнгийг шүүх гэм буруутай этгээдээр гаргуудан улс, орон нутгийн өвт оруулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Сонгууль зарлах, сонгуулийн хэсэг байгуулах

5 дугаар зүйл. Сонгууль зарлах

1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийг сана авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурал товлот зарлана.

2. Сонгогчдын саналыг ажлын болон баяр ёслолын бус өдөр авч **6 дугаар зүйл. Сонгуулийн хэсэг, түүнийг байгуулах**

Сонгогчдын санал авч тоолох зорилгоор сонгуулийн хэсгийг сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид санал авч өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө байгуулж, хэсгийн дугаар нутаг дэвсгэр, төвийг зарлана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Сонгууль эрхлэн явуулах байгууллага,
түүний бүрэн эрх

7 дугаар зүйл. Сонгуулийн хороо

1. Сонгууль бэлтгэн явуулах ажлыг дараахь байгууллага эрхэлнэ:

1/Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хороо;

2/аймаг, нийслэлийн сонгуулийн хороо;

3/сум, дүүргийн сонгуулийн хороо;

4/сонгуулийн хэсгийн хороо.

2. Сонгууль бэлтгэн явуулахад тухайн орон нутгийн байгууллаг албан тушаалтан холбогдох хууль тогтоомжид заасны даг оролцоно.

3. Сонгууль бэлтгэн явуулах ажил ил тод байна. Энэ заа сонгогчдын санал нууцаар авахад хамаарахгүй.

8 дугаар зүйл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль явуулах талаарх Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны бүрэн эрх

1. Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хороо /цаашид "Сонгуулийн ерөнхий хороо" гэх/ үйл ажиллагаагаа би даан явуулах бөгөөд түүний бүрэн эрх нь Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн хуулийн 11 дүгээр зүйлд заасна тодорхойлогдоно.

2. Сонгуулийн ерөнхий хороо иргэдийн Төлөөлөгчдийн Хурлы сонгуулийг бэлтгэн явуулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүд нэгдсэн удирдлагаар хангана.

9 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, түүний бүрэн эрх

1. Аймаг, нийслэлийн хэмжээнд сонгууль бэлтгэн явуулах ажил зохион байгуулах, санал хураалтын дүнг нэгтгэн гаргах зорилго тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлы

Тэргүүлэгчид санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, нийтэд мэдээлнэ. Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны бүрэлдэхүүний тоог ажлын хэмжээ, намын төлөөллийг харгалзан тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид тогтооно.

2. Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид нэр дэвшигч байж болохгүй.

3. Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд аль нэгэн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар сурталчилгаа явуулахыг хориглоно.

4. Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нутаг дэвсгэрийнхээ сэмжээнд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/сонгууль бэлтгэн явуулах ажлыг зохион байгуулах;

2/сонгуулийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгаж, сахин биелүүлэх явдлыг хангах, доод шатны сонгуулийн хороодын үйл ажиллагааг нэгтгэн удирдах;

3/сонгууль бэлтгэн явуулах асуудлаар тухайн нутаг дэвсгэр дэх төрийн зохих шатны байгууллагатай хамтран ажиллах;

4/сонгууль бэлтгэн явуулах асуудлаар сонгуулийн хэсгийн хороо, ухайн нутаг дэвсгэрийн төрийн зохих шатны байгууллагын дардагчдын мэдээллийг сонсож, шаардлагатай арга хэмжээ авах;

5/сонгуулийн хууль тогтоомж зөрчсөнтэй холбогдсон өргөдөл, омдлыг хянан шийдвэрлэх;

6/сонгуулийн саналын хуудсыг хэвлүүдэх, хуваарилах, тараах, оцоолох;

7/сонгуулийн нэгдсэн дүнг гаргаж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг бүртгэж, тэдний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх асуудлыг бэлтгэж аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

8/дахин санал авах, сонгууль явуулах ажлыг зохион байгуулах;

9/сонгуулийн холбогдолтой баримт бичгийг холбогдох хороодоос атан авч архивлах ажлыг зохион байгуулах;

10/хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх, Сонгуулийн рөнхий хорооноос өгсөн үүргийг биелүүлэх.

10 дугаар зүйл. Сум, дүүргийн сонгуулийн хороо,

түүний бүрэн эрх

1. Сум, дүүргийн хэмжээнд сонгууль бэлтгэн явуулах ажлыг зохион байгуулах, санал хураалтын дүнг нэгтгэн гаргах зорилгоор ухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эргүүлэгчид санал авах өдрөөс 20-иос доошгүй хоногийн өмнө

сум, дүүргийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, нийтэд мэдээлнэ. Сум, дүүргийн сонгуулийн хорооны бүрэлдэхүүний тоог ажлын хэмжээ, намын төлөөллийг харгалзан тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид тогтооно.

2.Сум, дүүргийн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид нэр дэвшигч байж болохгүй.

3.Сум, дүүргийн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд аль нэгэн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар сурталчилгаа явуулахыг хориглоно.

4.Сум, дүүргийн сонгуулийн хороо нь нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 1, 2, 3, 4, 5, 8-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

2/аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн дүнг нэгтгэн аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд хүргүүлэх;

3/сонгуулийн нэгдсэн дүнг гаргаж, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг бүртгэж, тэдний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх асуудлыг бэлтгэн, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

4/сонгуулийн холбогдолтой баримт бичгийг тогтоосон журмын дагуу цэгцэлж, аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд хүлээлгэн өгөх;

5/хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх, аймаг, нийслэлийн сонгуулийн хорооноос өгсөн үүргийг биелүүлэх.

11 дүгээр зүйл. Сонгуулийн хэсгийн хороо, түүний бүрэн эрх

1.Сонгуулийн хэсгийн хороог санал авах өдрөөс 20-иос доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид байгуулж, нийтэд мэдээлнэ. Сонгуулийн хэсгийн хорооны бүрэлдэхүүний тоог сонгогчдын тоо ажлын хэмжээг харгалзан тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид тогтооно.

2. Сонгуулийн хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид нэр дэвшигч байж болохгүй.

3. Хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар сурталчилгаа явуулахыг хориглоно.

4. Сонгуулийн хэсгийн хороо дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/сонгуулийн хэсгийн хаяг, ажиллах цагийн хуваарь, санал авах өдөр, цагийг сонгогчдод мэдээлэх;

2/сонгогчдын нэрсийн жагсаалтыг хэсгийн хэмжээнд нэгтгэн шалгах;

3/санал авах байр, саналын хуудас, хайрцгийг бэлтгэж, сонгогчдын санал авах ажлыг зохион байгуулах;

4/санал хураалтын дүнг гаргаж сум, дүүргийн сонгуулийн хороонд хүргүүлэх;

5/сонгуулийн холбогдолтой баримт бичгийг тогтоосон журмын дагуу цэгцэлж, сум, дүүргийн сонгуулийн хороонд хүлээлгэн өгөх;

6/сонгууль бэлтгэн явуулахтай холбогдсон өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, холбогдох байгууллагад уламжлах;

7/хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх, сум, дүүргийн сонгуулийн хорооноос өгсөн үүргийг биелүүлэх.

12 дугаар зүйл. Сонгуулийн хорооны ажлын зохион байгуулалт

1. Сонгуулийн хороод өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг хуралдаанаараа хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэж тогтоол гаргана. Гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсон бол сонгуулийн хорооны хуралдааныг хүчинтэйд тооцно.

2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны дарга дотоод ажлын асуудлаар захирамж гаргана.

3. Сонгуулийн хороо нь ажлын шаардлага, зардлын хэмжээг харгалзан гишүүдээ үндсэн ажлаас нь түр чөлөөлж ажиллуулна.

4. Сонгуулийн хэсгийн хорооны шийдвэрийн талаар сум, дүүргийн сонгуулийн хороонд, сум, дүүргийн сонгуулийн хорооны шийдвэрийн талаар аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд гомдол гаргаж болно. Гомдлыг хүлээж авснаас хойш ажлын 5 өдрийн дотор хянан шийдвэрлэж хариу мэдэгдэнэ.

5. Сонгуулийн хороо сонгууль бэлтгэн явуулахтай холбогдсон асуудлаар төр, нам, олон нийтийн зохих шатны байгууллага, албан тушаалтанд хууль ёсны шаардлага тавих эрхтэй бөгөөд байгууллага, албан тушаалтан тухайн шаардлагыг хүлээж авснаас хойш ажлын 5 өдрийн дотор шийдвэрлэж хариу мэдэгдэнэ.

6. Сонгуулийн хорооноос бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг тухайн нутаг дэвсгэрийн төр, нам, олон нийтийн байгууллага, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Сонгогчдын нэрийг жагсаалт

13 дугаар зүйл. Сонгогчдын нэрийн жагсаалт, түүнийг үйлдэх, танилцуулах

1. Сонгогчдын нэрийн жагсаалтыг сонгуулийн хэсэг бүрээр үйлдэж, сонгогчдын тоог аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороонд нэгтгэнэ.

2. Сонгогчдын нэрийн жагсаалтад түүнийг үйлдэх үед сонгуулийн тухайн хэсэгт байнга оршин суугаа бүх сонгогчийн овог нэр, нас, оршин сууж байгаа газрын хаяг, иргэний паспортын болон регистрийн дутаарыг бүртгэнэ. Цагдаагийн байгууллага болон эмнэлэг, амралт, сувиллын газрын эрх баригчид сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэхэд шаардагдах мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

3. Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нутаг дэвсгэртээ оршин сууж байгаа сонгогчдын нэрийн жагсаалтыг байнгын оршин суугаа хаягийн бүртгэлийн дагуу Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтаар хоёр хувь үйлдэж, санал авах өдрөөс 15 хоногийн өмнө сонгуулийн хэсгийн хороонд хүргүүлнэ.

4. Сонгуулийн хэсгийн хороо сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс 12-оос доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтын дагуу хоёр хувь үйлдэж, хэсгийн хорооны дарга гарын үсгээ зурж, санал авах өдрөөс 10-аас доошгүй хоногийн өмнө ил тавьж, сонгогчдод чөлөөтэй танилцах бололцоо олгоно.

14 дүгээр зүйл. Сонгогчдын нэрийн жагсаалтын талаар гомдол гаргах

1. Сонгогчийг сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгээгүй буюу буруу бүртгэсэн байвал тэрээр тухайн сонгуулийн хэсгийн хороонд гомдол гаргах эрхтэй.

2. Сонгуулийн хэсгийн хороо уг гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 2 өдрийн дотор хянан үзэж, сонгогчдын нэрийн жагсаалтад зохих өөрчлөлт оруулах буюу гомдлыг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргаж, хариу мэдэгдэнэ. Сонгогч уг шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргана.

15 дугаар зүйл. Сонгогч шилжих

Сонгогч санал авах өдрөөс өмнө аймаг, нийслэл, сум, дүүрэг дотроо нэг хэсгээс нөгөө хэсэгт шилжвэл сонгуулийн хэсгийн хороонд очиж сонгогчдын нэрийн жагсаалтаас хасуулан, очсон газрынхаа сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид нэр дэвшүүлэх, нэр дэвшигчийг бүртгэх

16 дугаар зүйл. Нэр дэвшүүлэх хугацаа

1. Нэр дэвшүүлэх ажлыг сонгууль зарласнаас хойш 7 хоногийн дараа эхэлж 10 хоногийн хугацаанд дуусгана.

2. Энэ хуудийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид нэр дэвшигчдийн үүртгэлд бүртгүүлж, үнэмлэх авсан хүнийг нэр дэвшигч гэж тооцно.

17 дугаар зүйл. Нам, эвслээс нэр дэвшүүлэх

1. Сонгууль зарлахаас өмнө улсын бүртгэлд бүртгэгдсэн аймаг, нийслэл, сум, дүүрэгт өөрийн салбар байгууллагатай нам, эвсэл сонгуульд оролцох эрхтэй. Нам, эвслийн эдгээр салбар байгууллага ангаараа буюу хамтран тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид нэр дэвшүүлж болно. Улсын Их Хурал болон Ерөнхийлөгчийн сонгуульд эвсэлд нэгдэж орсон намуудын салбар байгууллага эвслийн гэрээний хугацаанд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд эвсэн оролцож болно.

Нам, эвсэл улс төрийн өөр намын гишүүнийг өөрийн нэрийн мнөөс нэр дэвшүүлж болохгүй.

2. Нам, эвсэл иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд дараалалд оруулсан нэрсийн жагсаалтаар нэр дэвшигчдээ дэвшүүлнэ. Үнэхүү нэрсийн жагсаалтаасаа аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд сум, дүүрэг тус бүрд нэг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд баг, хороо тус бүрд нэг үний нэрийг нам, эвслийнхээ нэрийн өмнөөс засаг захиргаа, нутаг эвсгэрийн нэгжийг төлөөлөн сонгогдох суудалд нэр дэвшүүлж олно.

3. Нам, эвслээс нэр дэвшигчдийн тоо нь тухайн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн хуулиар тогтоосон тооноос лүү байж болохгүй.

Нам, эвслийн салбар байгууллага нэр дэвшүүлэхдээ доод татныхаа байгууллагын саналыг харгалзсан байвал зохино.

4. Нам, эвслийн салбар байгууллага нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид нэр дэвшүүлсэн тухай шийдвэрээ нэр дэвшигчдийн бичгээр өгсөн зөвшөөрөл, Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоосон загварын дагуу үйлдсэн намтрын хамт аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороонд хүргүүлнэ.

18 дугаар зүйл. Бие даан нэрээ дэвшүүлэх

1. Иргэн өөрийн харьяалагдах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн

нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөх төлөөлөгчид бие даан нэр дэвшүүлэх эрхтэй.

2.Бие даан нэрээ дэвшүүлэгч нь аймаг, нийслэлд 151, сум дүүрэгт 75-аас доошгүй сонгогч-дэмжигчдийн гарын үсгийг Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоосон загвараар үйлдсэн маягтын дагуу зуруулж, аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороонд бүртгүүлнэ.

3.Бие даан нэр дэвшигч нь дэмжигчдийнхээ гарын үсэг бүхн маягтыг Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоосон загварын дагуу үйлдсэн намтар, нэр дэвшүүлсэнээ илэрхийлсэн мэдэгдлийн хамт аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороонд өгнө.

4.Нэр дэвшигчийг дэмжсэн сонгогч-дэмжигчдийн гарын үсэг үнэн зөв эсэхийг аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо сонгогчдын иргэний баримт бичиг, хаягийн бүртгэлтэй тулгах буюу шаардлагатай бол дэмжигчидтэй уулзаж нягтлан шалгана. Гарын үсгийг хуурамчаар үйлдсэн бол тухайн хүн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид нэр дэвшсэнийг холбогдох сонгуулийн хороо хүчингүйд тооцно.

19 дүгээр зүйл. Нэр дэвшигч, тэдгээрийн жагсаалт

1.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид нэр дэвшигч нь аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэр дэвшигч байж болно.

2.Нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг сонгуулийн хэсгийг хорооны байранд байрлуулан, орон нутгийн сонин хэвтэлд нийтэл нийтэд танилцуулна.

3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт тус тусдаа байна.

20 дугаар зүйл. Нэр дэвшигчийг бүртгэх

1.Нам, эвслээс болон бие даан нэр дэвшигчийг аймаг, нийслэл сум, дүүргийн сонгуулийн хороо сонгууль зарласнаас хойш 1 хоногийн дотор бүртгэж үнэмлэх олгоно. Нэр дэвшигчийг бүртгэхдээ нам, эвслээс ирүүлсэн баримт бичиг үнэн зөв, гүйцэж эсэх, нэр дэвшүүлэх үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдсан эсэхийг нягтлан шалгана.

2.Сонгуулийн хороод нэр дэвшигчийг бүртгэсэн тухай шийдвэр гаргах бөгөөд сум, дүүргийн сонгуулийн хороо энэ шийдвэр аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд хүргүүлнэ. Нэр дэвшигчийг бүртгэх хугацаа дууссанаас хойш сум, дүүргийн сонгуулийн хороо ажлын 3 өдрийн дотор аймаг, нийслэлийн сонгуулийн хороо ажлын

6 өдрийн дотор нийт нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээгээр нэгтгэн гаргаж, нийтэд мэдээлнэ.

21 дүгээр зүйл. Нэр дэвшүүлсэн шийдвэрийг хүчингүй болгох, нэр дэвшигч татгалзах

1. Нэр дэвшигч өөрөө татгалзах буюу нам, эвсэл нь нэр дэвшүүлэгчээ татан гаргах, түүний оронд өөр хүний нэр дэвшүүлэх эрхтэй. Нэр дэвшигч буюу нам, эвсэл энэ тухай шийдвэрээ аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороонд нэн даруй мэдэгдэнэ. Нэр дэвшсэнийг хүчингүйд тооцсон тухай аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны шийдвэр, нэр дэвшигч өөрөө татгалзсан буюу, эсхүл нам, эвсэл өөрийн нэр дэвшигчийг татан аргасан тухай аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо тутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтэд мэдээлнэ.

2. Нам, эвсэл нэр дэвшигчээ татан гаргасан тухайгаа санал авах өдрөөс 15-аас доошгүй хоногийн өмнө аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороонд мэдэгдээгүй бол татан гаргасан нэр дэвшигчийн оронд өөр хүний нэр дэвшүүлэх эрхгүй.

22 дугаар зүйл. Нөхөн нэр дэвшүүлэх

Нэр дэвшигч нас барсан, түүнчлэн энэ хуулийн 21 дүгээр үйлийн 2 дахь хэсэгт заасан хугацааны өмнө нам, эвсэл нэр дэвшигчээ татан авсан тохиолдолд тухайн нам, эвсэл өөр хүний гэрийг нөхөн дэвшүүлж, санал авах өдрөөс 12 хоногийн өмнө аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороонд бүртгүүлж олно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

**Сонгуулийн өмнөх ухуулга, сурталчилгаа,
нэр дэвшигчийн үйл ажиллагааны баталгаа**

**23 дугаар зүйл. Сонгуулийн өмнөх ухуулга, сурталчилгаа,
уулзалт**

1. Нам, эвсэл нэр дэвшигч нь сонгуулийн өмнөх сурталчилгаа вуулахдаа Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 21 дүгээр үйлийн 1, 2, 5, 6 дахь хэсгийн заалтыг баримтална.

2. Орон нутгийн радио, телевизээр сонгуулийн ухуулга, сурталчилгаа үнэ төлбөргүй явуулах хугацаа, боломж нь нам, эвсэл бүрт, түүнчлэн сонгуульд өрсөлдөгч бие даан нэр дэвшигчдэд харилцан ил байна.

3. Сонгуулийн хорооноос тогтоож олгосон хугацаанаас бусад цагт нам, эвсэл, нэр дэвшигч орон нутгийн радио, телевизээр сурталчилгаа явуулбал үнэ хөлсийг төлнө.

4. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч сонгогчидтойгоо уулзалт хийж болно.

5. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сонгуулийн ухуулга, сурталчилгаа, нэр дэвшигчийн сонгогчидтойгоо хийх уулзалтыг санал авах өдрөөс 24 цагийн өмнө зогсооно.

24 дүгээр зүйл. Нэр дэвшигчдэд туслах

1. Нэр дэвшигчдэд туслах үйл ажиллагаа нь Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 29 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсгийн заалтааг зохицуулагдана.

2. Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын сонгууль эрхэлсэн байгууллагын бүрэлдэхүүн, ажилтан, бие даан нэр дэвшигчийг шадар туслагч аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороонд бүртгүүлж, үнэмлэх авна.

25 дугаар зүйл. Нэр дэвшигчийн үйл ажиллагааны баталгаа

1. Хэвтэл, мэдээллийн хэрэгслээр нам, эвслийн нэр дэвшигч нам эвслийнхээ, бие даан нэр дэвшигч өөрийн хөтөлбөрийг тайлбарлах үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ухуулга, сурталчилгаа хийх аймаг, нийслэл, сум, дүүргийнхээ холбогдох байгууллагаас зохижурмын дагуу шаардлагатай мэдээлэл, лавлагаа авах эрх эдэлнэ.

2. Нэр дэвшигчийг гүтгэх, доромжлох, нэр төрийг нь гутаах түүний хувийн болон захидал харилцааны нууцыг задруулахыг хориглоно.

3. Нэр дэвшигчид түүний ажлын газар, байгууллагын захирга хууль тогтоомжид заасны дагуу ажлаас нь чөлөө олгоно.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн санал авах, дүнг гаргах, Хурлын Төлөөлөгчийг бүртгэх

26 дугаар зүйл. Санал авах байр, хугацаа

1. Сонгогчдын саналыг санал авах өдөр 7.00 цагаас оройн 22.0 цаг хүртэл санал авах байранд авна. Сонгогчдын санал авах өдөр цаг, байрыг сонгуулийн хэсгийн хороо санал авах өдөр хүртэл 1 хоногийн турш нийтэд зарлан мэдээлнэ.

2. Сонгогчдоос саналаа нууцаар гаргахад хүрэлцэх тооны тасалгыг саналын хайрцаг бүхий байрыг тухайн сонгуулийн хэсгийг харьяалагдах баг хорооны Засаг дарга хариуцаж бэлтгүүлнэ.

27 дугаар зүйл. Саналын хуудас

1. Саналын хуудас нь сонгогчоос саналаа илэрхийлэх, сонгуулийн дүнг гаргах үндсэн баримт бичиг болно.

2. Саналын хуудсыг Улсын Их Хурлаас баталсан загварын дагуу аймаг, нийслэлийн сонгуулийн хороо эрхлэн хэвлэж, сум, дүүргийн сонгуулийн хороонд санал авах өдрөөс 10-аас доошгүй хоногийн өмнө, сонгуулийн хэсгийн хороонд 5-аас доошгүй хоногийн өмнө үрсэн байхаар зохион байгуулна.

3. Саналын хуудсанд нам, эвслийн дарааллыг улс төрийн намуу-ыг Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллаар бичиж хэвлэнэ. Эвслийг дараалалд оруулахдаа эвсэлд оролцогч намуудаас хамгийн үрүүнд Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн намын дарааллаар тогтооно. Нам, эвслийн нэрээр санал хураах хуудас нь аймаг, сум болон нийслэл, дүүргээр нь зааглан бичсэн нэг хуудас байна.

4. Засаг захиргаа нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгжийг төлөө-өн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид нэр дэвшигч-ийн саналын хуудсыг хэвлэхдээ аймаг, сумын, иргэдийн Төлөө-өгчдийн Хурал; нийслэл дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид гэдгээр нь зааглан бичнэ.

5. Бие даан нэр дэвшигчийг нам, эвслээс нэр дэвшигчдийн дараа аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороонд бүртгүүлсэн арааллаар бичнэ.

6. Саналын хуудсанд тухайн хэсгийн хорооны дарга, нарийн ичгийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарна. Гарын үсэг, тэмдэггүй зналын хуудсаар санал өгч болохгүй.

28 дугаар зүйл. Санал авах ажлыг зохион байгуулах

1. Санал авахаар товлосон өдрийн өглөөний 7.00 цагт сонгуулийн хэсгийн хорооны бүрэлдэхүүн сонгогчдын төлөөлөгчдийг байл-уулан саналын бүх хайрцгийг шалган битүүмжилж, санал авах киллагааг эхэлнэ. Энэ ажиллагаанд нам, эвслээс томилогдсон киглагчид байлцаж болно.

2. Ажиглагч нь аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хо-роонд бүртгүүлж үнэмлэх авна. Ажиглагч сонгогчдын санал авах, санал тоолох, сонгуулийн дүн гаргах үед уг ажиллагаа хууль тог-зомжийн дагуу явагдаж байгаа эсэхийг хөндлөнгөөс ажиглан хянах хтэй бөгөөд сонгуулийн хороодын үйл ажиллагаанд хутгалдан оролцож болохгүй.

3. Сонгуулийн хэсгийн хороо сонгогчийн иргэний паспорт, түүн-ий адилтгах баримт бичгийг нэрийн жагсаалттай тулган шалгаж, нгөгч бүрт саналын хуудас олгоно.

4. Санал авах өдөр сонгуулийн өөр хэсгээс шилжин ирсэн нгөгчдыг иргэний паспорт, түүнтэй адилтгах баримт бичгийг нь цэслэн нэрийн нэмэлт жагсаалтад бүртгэж, саналын хуудас гноно.

5. Саналын хуудас олгосныг сонгогчдын нэрийн жагсаалтад, саналаа өгснийг иргэний паспорт, түүнтэй адилтгах бичиг баримтад тэмдэглэн сонгуулийн хэсгийн хорооны тэмдэг дарна.

29 дүгээр зүйл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгоход санал өгөх

1. Сонгогч санал авах байранд биечлэн ирж саналаа өгнө. Харин биеийн эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас санал авах байранд хүрэлцэн ирж чадахгүй сонгогчийн саналыг түүний хүсэлтээр сонгуулийн хэсгийн хорооны 2-оос доошгүй гишүүн очиж, битүүмжилсэн хайрцагаар авна.

2. Саналын хуудсыг сонгуулийн хэсэгт ирүүлснээс хойш санал авах өдөр хүртэл сонгогч түр шилжин явахад хүрвэл сонгуулийн хэсгийн хороонд ирж саналын хуудас авч саналаа нууцаар тэмдэглэж дугуйлан битүүмжлэн үлдээж болно. Сонгуулийн хэсгийн хороо сонгогчийн битүүмжлэн үлдээсэн саналын нууцыг чандлан хадгална.

3. Сонгогч саналын хуудсыг авч санал бэлтгэх тасалгаанд орж, уг хуудсанд бичигдсэн нам, эвслийн төлөө саналаа өгөхдөө өөрийн дэмжиж байгаа аль нэг нам, эсхүл эвслийн өмнөх дугаарыг, заса захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөн нам, эвслээс нэг дэвшигч болон бие даан нэр дэвшигчийн төлөө саналаа өгөхдөн өөрийн сонгохыг хүсч байгаа аль нэг нэр дэвшигчийн овог, нэрийн өмнөх дугаарыг дугуйлан тэмдэглээд саналын хайрцагт хийнэ.

4. Сонгогч саналаа илэрхийлэхдээ алдаа гаргаж буруу тэмдэглэсэн бол уг саналын хуудсаа саналын хайрцагт хийхээс өмнө хэсгийн хороонд энэ тухайгаа мэдэгдэж хуудсаа хураалтан, дахин нэг саналын хуудас авч болно. Хураалтсан саналын хуудсыг сонгуулийн хэсгийн хороо протоколд тэмдэглэж хадгална.

5. Санал бэлтгэх тасалгаанд тухайн сонгогчоос өөр хэн ч байх болохгүй. Саналын хуудсанд саналаа өөрөө тэмдэглэж чадахгүй сонгогч өөрийн итгэмжилсэн хүний туслалцаа авч болно. Харин ал нэг нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, сонгуулийн хорооны гишүүн болон ажиглагчдаар ийнхүү туслалцуулж болохгүй.

6. Саналын хайрцагт саналын илүү буюу өөр хуудас хийх зэргээ сонгогчоос буруу үйлдэл гаргуулахгүйн тулд сонгогчийн саналын нууцыг алдагдуулахгүйгээр сонгуулийн хэсгийн хорооноос хянал тавина.

30 дугаар зүйл. Саналын хуудсыг хүчингүйд тооцох

1. Дор дурдсан тохиолдолд саналын хуудсыг хүчингүйд тооцно:

1/батлагдсан загварын бус хуудсаар санал өгсөн;

2/сонгуулийн хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн даргын гарын үсэг, хэсгийн хорооны тэмдэггүй хуудсаар санал өгсөн;

3/энэ хуульд зааснаас өөр тэмдэглэл хийсэн нь аль нэгэн нам, эвсэл буюу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөн нэр дэвшигчид саналаа өгсөн нь тодорхойгүй бол;

4/санал огт тэмдэглээгүй;

5/бүх нэр дэвшигчид нам, эвслийн нэрийг дарсан.

2.Харин сонгогч нам, эвслийн нэрээр болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөх нэр дэвшигчийн төлөө саналаа өгөхдөө зөвхөн нэг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөтөгчдийн Хурлын хувьд нэг удаа тэмдэглэсэн бол энэ нь уг саналын хуудсыг хүчингүйд тооцох үндэслэл болохгүй.

31 дүгээр зүйл. Санал тоолох

1.Санал тоолох ажлыг санал авахаар товлосон өдрийн оройн 12.00 цагт эхэлж, ил тод, нээлттэй явуулна. Санал тоолоход ижиглагчид, сонгогчдын болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчид байлцаж болно.

2.Оройн 22.00 цаг болмогц сонгуулийн хэсгийн хорооноос санал тоолох тухай мэдэгдэж, олгоогүй үлдсэн саналын хуудсыг тоолж итгүүмжилсний дараа саналын хайрцгийг нээнэ. Санал тоолох цаг юолоогүй байхад саналын хайрцаг нээх, санал тооллогыг авсарлахыг хориглоно.

3.Сонгуулийн хэсгийн хороо сонгогчдын нэрийн жагсаалтыг иримтлан тухайн хэсгийн нийт сонгогчдын тоо, саналын хуудас авсан сонгогчдын тоо саналын хайрцагаас гарсан хүчинтэй болон үчингүй хуудасны тоо, нам, эвсэл, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөн нам, эвслээс нэр дэвшигч, бие даан нэр дэвшигч үрийн төлөө өгсөн саналын тоог сонгуулийн хэсгийн хэмжээгээр болж гаргана.

4.Сонгуулийн хэсгийн хороо хуралдаанаараа сонгогчдын санал болсон дүнг хэлэлцэн шийдвэр гаргаж уншин сонгоно. Уул ийдвэрт сонгуулийн хэсгийн хорооны дарга, гишүүд, ажиглагчдын төлөөлөгчид гарын үсэг зурж, хэсгийн тэмдэг дарсны дараа итгүүмжлэн аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороонд нэн ирүй хүргүүлднэ.

**32 дугаар зүйл. Сонгуулийн дүнг гаргах, иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг
бүртгэх**

1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо нь энгуулийн хэсгийн хорооны шийдвэрийг үндэслэн аймаг, нийслэл, /м, дүүргийн нийт сонгогчдын тоо, саналын хуудас авсан энгогчдын тоо, хүчинтэй, хүчингүй хуудасны тоо болон нам,

эвслийн төлөө өгсөн саналын тоог аймаг, нийслэл, сум, дүүрэг бүрээр; засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөн нам эвслээс буюу бие даан нэр дэвшигч бүрийн төлөө өгсөн саналыг тоог сум, дүүрэг, баг, хороо бүрээр нэгтгэн гаргана.

2. Сонгуулийн дүнг гаргахдаа саналын хүчинтэй хуудсаар тооцно.

3. Тухайн сум, дүүрэг, баг, хороонд сонгогчдын хамгийн оло санал авсан нам, эвслээс буюу бие даан нэр дэвшигчийг сум дүүрэг, баг, хороог төлөөлөн аймаг, нийслэл, сум, дүүргий иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдсонд тооцно.

Нэр дэвшигчдийн сонгогчдоос авсан санал тэнцсэн тохиолдол тэдгээр нэр дэвшигчдийг дахин санал хураалтад оруулж хамгийн олон санал авсныг нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдсонд тооцно.

4. Нам, эвслийн нэрийн жагсаалтаар нийт сонгогчдын өгсө саналын дүнг аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд нам, эвсэ бүрээр нэгтгэн гаргана.

Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид бие даан нэр дэвшиж сонгогдсон нэр дэвшигчдэд ногдох иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн суудлыг хасаж, үлдсэн суудлыг нийт сонгогчды 5-аас дээш хувийн санал авсан нам, эвсэлд авсан саналтай нь хуу тэнцүүлэн хуваарилна.

5. Нам, эвсэлд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн суудлыг дор дурдсан журмаар хувь тэнцүүлэн хуваарилна:

1/хүчинтэй саналын хуудасны тоог тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн нам, эвсэлд оногдох нийт суудлыг тоонд хувааж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэг суудалд ногд саналын тоо /квот/-г тогтооно;

2/нам, эвслийн авсан нийт саналын тоог нэг суудалд оногд саналын тоо /квот/-нд хувааж, тухайн нам, эвсэлд ногдох суудлыг тоог тогтооно;

3/нийт сонгогчдын 5-аас дээш хувийн санал авсан нам, эвсэл энэ хэсэгт заасан журмаар суудал хуваарилсны дараа суудал үлдээ үлдсэн суудлыг хамгийн их үлдэгдэл саналтай байгаа нам, эвслээ эхлэн /их үлдэгдэл саналын зарчмаар/ хуваарилж дуусгана.

6. Нам, эвсэлд ногдсон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын суудал энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар сонгогдсон нэр дэвшигч хуваарилагдаж, үлдсэн суудалд нам, эвслийн нэрийн жагсаалт бичигдсэн дарааллаар нэр дэвшигчид сонгогдоно.

7. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нам, эвслээс нэр дэвшигчдэн энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар сонгогдсон нэр дэвшигчдийн тоо нь тухайн нам, эвсэл

ногдсон суудлын тооноос давсан тохиолдолд нам, эвслийн суудлын харьцаа нь хадгалагдсан байх үндсэн дээр иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгчдийн хуулиар тогтоосон тоо нэмэгдэж болно.

8. Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн дүнг нам, эвсэл болон засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөн нам, эвслээс буюу бие даан нэр дэвшигч тус бүрээр тооцон ажлын 7 хоногт багтаан гаргаж хуралдаанаараа хэлэлцэнэ. Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдогсдын нэрсийн жагсаалтыг тэдгээрийн бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрүүлэхээр шинээр сонгогдсон иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Санал хураалт болон сонгуулийг хүчингүйд тооцох,
дахин санал хураалт, сонгууль явуулах, иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийг өөхөн
сонгогдсонд тооцох

33 дугаар зүйл. Сонгуулийн хэсэгт явагдсан санал хураалтыг
хүчингүйд тооцох, дахин санал
хураалт явуулах

1. Сонгуулийн хэсэгт явагдсан санал хураалтыг сум, дүүргийн сонгуулийн хороо дор дурдсан тохиолдолд хүчингүйд тооцно:

1/байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, хүндэтгэн үзэх өөр шалтгаанаас бусад нөхцөлд урьд зарласнаас өөр байранд, түүнчлэн шилжигчдийн саналыг битүүмжилж авснаас бусад тохиолдолд урьд зарласнаас өөр өдөр санал авсан;

2/санал хурааж эхэлснээс хойш саналын хайрцгийг алдсан, үрэгдүүлсэн, хуульд заасан цагаас өмнө нээсэн;

3/сонгуулийн хорооны гишүүн буюу сонгогчдод хүч хэрэглэн дарамт үзүүлсэн аливаа үйлдэл нь сонгогчийн санал, сонгуулийн дүнг гажуудуулахад хүргэсэн;

4/сонгуулийн хорооны гишүүн бусад байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх, хууран мэхлэх зэргээр сонгуулийн хуулийг зөрчсөн нь сонгуулийн дүнд ноцтой нөлөөлсөн.

2. Санал хураалтыг хүчингүйд тооцсон тохиолдолд энэ тухай холбогдох сонгуулийн хорооны шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор дахин санал хураалт явуулна. Дахин санал хураалт явуулах шийдвэрийг сум, дүүргийн сонгуулийн хороо гаргана. Уг шийдвэрт дахин санал авах байр, өдөр, цагийг заана. Санал хураалтыг хэсгийн хэмжээнд хүчингүйд тооцсон бол тухайн хэсгийн нийт сонгогч,

саналын тодорхой хайрцагт хураасан саналыг хүчингүйд тооцсон бол уг хайрцагт саналын хуудсаа хийсэн сонгогчдыг дахин санал хураалтад оролцуулна.

3. Дахин санал хураалт явуулах ажлыг дуустал ухуулга, сурталчилгаа хийхийг хориглоно.

34 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг хүчингүйд тооцох, дахин сонгууль явуулах

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг дээд шатны сонгуулийн хороо дараахь тохиолдолд хүчингүйд тооцно:

1/аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгогчдын 50 хувь нь санал хураалтад оролцоогүй;

2/энэ хуулийн 33 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу явуулсан дахин санал хураалт хүчингүй болсон нь тухайн шатны сонгуулийн дүнд ноцтой нөлөөлсөн.

2. Дахин сонгууль явуулах шийдвэрийг аймаг, нийслэлийн сонгуулийн хороо гаргана.

3. Дахин сонгуулийг тухайн сонгуулийг хүчингүйд тооцсон шийдвэр гарснаас хойш 20 хоногийн хугацаанд явуулна. Шаардлагатай бол сонгуулийн хороог шинэчлэн байгуулах, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид нэр дэвшүүлэх зэрэг уг сонгуулийг бэлтгэн явуулах ажилд энэ хуулийн холбогдох заалтыг баримтална.

35 дугаар зүйл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг нөхөн сонгох

1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөн нам, эвслээс буюу нэрээ бие даан дэвшүүлж сонгогдсон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нас барсан, хүсэлтээрээ чөлөөлөгдсөн, эгүүлэн татсан бол тухайн Хурлын төлөөлөгчдийн бүрэлдэхүүн гуравны хоёрт хүрэхгүй тохиолдолд нөхөн сонгууль явуулна.

2. Нам, эвслийн нэрийн жагсаалтаар сонгогдсон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нас барсан, хүсэлтээрээ чөлөөлөгдсөн, эсхүл түүнийг Хурлын төлөөлөгчөөс эгүүлэн татсан бол тухайн төлөөлөгчийн сонгогдсон Хуралд намынх нь нэрийн жагсаалтад үлдсэн нэр дэвшигчдийн дотроос хамгийн эхэнд байгаа хүнийг тухайн Хурлын төлөөлөгчөөр нөхөн сонгогдсонд тооцно.

3. Нам, эвслийн нэрийн жагсаалтаар сонгогдсон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нас барсан, хүсэлтээрээ чөлөөлөгдсөн, эсхүл түүнийг эгүүлэн татсан тохиолдолд нам, эвслийнх нь жагсаалтад нэр дэвшигч үлдээгүй, Хурлын төлөөлөгчдийн бүрэлдэхүүн нь гуравны хоёрт хүрэхгүй тохиолдолд нөхөн сонгууль явуулна.

4. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн нөхөн сонгууль явуулахад энэ хуулийн холбогдох заалтыг баримтлах бөгөөд нөхөн сонгуулийг дор дурдсан хугацаанд зохион байгуулна:

1/энэ зүйлийн 1, 3 дахь хэсэгт заасан нөхцөл байдал үүссэнээс хойш 15 хоногийн дотор аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид зарлаж, 30 хоногийн хугацаанд багтаан нөхөн сонгуулийг явуулна;

2/холбогдох сонгуулийн хороо, хэсгийг санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө, сонгуулийн хэсгийн хороог 20-иос доошгүй хоногийн өмнө тус тус байгуулна;

3/нэр дэвшүүлэх ажлыг нөхөн сонгууль зарласнаас хойш 7 хоногийн дараа эхэлж, 10 хоногийн хугацаанд дуусгана;

4/сонгогчдын нэрийн жагсаалтыг хуульд заасан журмын дагуу үйлдэж санал авах өдрөөс 15 хоногийн өмнө сонгуулийн хэсгийн хороонд өгнө. Хэсгийн хороо энэ жагсаалтыг санал авах өдрөөс 10-аас доошгүй хоногийн өмнө сонгогчлод танилцуулах ажлыг зохион байгуулна.

5. Нөхөн сонгогдсон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан төлөөлөгчийн бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

36 дугаар зүйл. Сонгуулийн эрхийг хангах хууль зүйн баталгаа

1. Төрийн байгууллагаас сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгахад нэр дэвшигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан оролцохыг хориглоно.

2. Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн нь тогтоогдвол гэм буруутай этгээдэд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

3. Сонгогчоос сонгуулийн эрхээ хэрэгжүүлэх буюу сонгуулийн хороо, түүний гишүүнээс үүргээ гүйцэтгэхэд нь санаатайгаар саад хийх, сонгуульд оролцохоос татгалзахыг нийтэд уриалах, сүсэг бишрэлийг далимдуулах, бусдын нэрийн өмнөөс сонгуульд оролцох, санал худалдаж авах, эд хөрөнгөөр татах, санал тоолох ажлыг зориуд саатуулах болон бусад хэлбэрээр сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдийг шүүх 50000 хүртэл төгрөгөөр торгоно.

4. Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 2, 12 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасан үүргийг биелүүлээгүй албан тушаалтныг сахилгын

хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүх 50000 хүртэл төгрөгөөр торгоно.

5.Нэр дэвшигч, нам, эвсэл, талархан дэмжигч байгууллага сонгогчдыг татах зорилгоор тэдэнд үнэ төлбөртэй болон төлбөргүйгээр бараа тараах, ахуйн үйлчилгээ /соёлын үйлчилгээнээс бусад/ үзүүлэхийг хориглоно. Энэ заалтыг зөрчсөн нам, эвсэл, байгууллагыг шүүх 250000 хүртэл төгрөгөөр, иргэнийг 50000 хүртэл төгрөгөөр тус тус торгоно.

6.Энэ хуулийн 23 дугаар зүйлийн 5, 33 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмыг нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, албан тушаалтан зөрчвөл уг үйлдлээ зогсоохыг шаардах бөгөөд энэ шаардлагыг эс биелүүлбэл шүүх тухайн нам, эвсэл, бусад байгууллагыг 250000 хүртэл, гэм буруутай албан тушаалтан, иргэнийг 50000 хүртэл төгрөгөөр тус тус торгоно. Хэрэв нэр дэвшигч буруутай бол түүнийг нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтаас хасах эрхийг аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо эдэлнэ.

7.Энэ хуулийн 13 дугаар зүйлийн 3, 26 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүргээ биелүүлээгүй Засаг даргыг сахилгын хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүх 10000 хүртэл төгрөгөөр торгоно.

8.Энэ хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн орон нутгийн радио, телевизийн байгууллагыг шүүх 250000 хүртэл төгрөгөөр торгоно.

9.Энэ хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдийг шүүх 50000 хүртэл төгрөгөөр торгоно.

10.Энэ хуулийн 9, 10, 11 дүгээр зүйлийн 2, 3; 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг зөрчсөн сонгуулийн хэсгийн хорооны гишүүнийг шүүх 10000 хүртэл төгрөгөөр торгоно.

11.Сонгуулийн хороонд ажиллахаар томилогдсон иргэн үүрэгт ажлаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй бол шүүх түүнийг 10000 хүртэл төгрөгөөр торгоно.

37 дугаар зүйл. Сонгуулийн холбогдолтой маргааныг шийдвэрлэх

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн талаарх аливаа маргааныг Үндсэн хуулийн цэц, шүүх, сонгуулийн хороод хууль тогтоомжид заасан харьяалал, журмын дагуу шийдвэрлэнэ.

38 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1996 оны 8 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 5 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 32

Улаанбаатар
хот

**Төрөөс хөдөөгийн талаар баримтлах
бодлогын үндсэн чиглэлийг
батлах тухай**

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

"Төрөөс хөдөөгийн талаар баримтлах бодлогын үндсэн чиглэл"-ийг хавсралтын ёсоор баталсугай.

Дарга

Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын 1996 оны
32 дугаар тогтоолын хавсралт

**ТӨРӨӨС ХӨДӨӨГИЙН ТАЛААР БАРИМТЛАХ
БОДЛОГЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

I. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Монгол Улсын зүн амыг хүнс, өргөн хэрэглээний бараагаар, үйлдвэрийг түүхий эдээр хангаж экспортын бүтээгдэхүүний нэлээд ээсгийг гаргадаг хөдөө аж ахуйн салбарыг онцлон үзэж, түүнийг төгжүүлэхэд төр, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн үйл оюуллагааг нэгтгэн чиглүүднэ.

2. Төрөөс хөдөөгийн талаар баримтлах бодлого нь монголчуудын амьдралын уламжлалт аж төрөх ёс, нүүдлийн соёл иргэншлийн үнэт үйлсийг дэлхийн хөгжлийн нийтлэг чиг хандлагатай уялдуулан төгжүүлэх замаар хөдөөд хүмүүс тухтай ажиллах, амьдрах нөхцөлийг ий болгох, хот, хөдөөгийн хоорондын эдийн засаг, ахуй, соёл, боловсролын гүншинг дээшлүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, хөдөө ж ахуйн үйлдвэрлэлийн өсөлт, үр ашгийг нэмэгдүүлэх, хүнсний үтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, байгаль орчны тэнцэл, ийгмийн тогтвортой хөгжлийг хангахад оршино.

3. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэн амьжиргааны болон рлогын үндсэн эх үүсвэрээ бүрдүүлж буй хүн ам ажиллаж, мьдардаг орчныг хөдөө гэж ойлгоно.

II. ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ

Монгол Улсын хөдөөгийн хөгжил нь бэлчээрийн мал аж ахуй, түүнд түшиглэсэн нүүдлийн ахуй соёлыг баяжуулан хадгалах шаардлага, дэд бүтцийн тэнхлэгүүдэд татагдсан хөдөөгийн сууринг хөгжүүлэх үндсэн дээр суурин соёл иргэншлийн дэвшилтэт ололтыг бүтээлчээр хэрэглэх хэрэгцээг тусгасан үндсэн чиглэлээр тодорхойлогдоно.

Энэхүү үндсэн чиглэл нь дор дурдсан зорилтуудаар дамжин хэрэгжинэ:

1/эдийн засгийн бүсчлэлийн асуудалтай холбогдуулан нүүдлийн болон суурин амьдралын хоорондын харьцаа, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан хоорондын уялдаа, суурин, хот орчмын хөдөө аж ахуйн хөгжил, хөдөөгийн дэд бүтцийн хөгжлийн асуудлуудыг цогцолбороор шийдвэрлэнэ;

2/эдийн засгийн бүсчлэл, дэд бүтцийн хөгжилтэй уялдуулан хөдөөгийн хөгжлийн талаар хөтөлбөр, дэд төсөл боловсруулж хэрэгжүүлнэ;

3/хөдөөгийн оршин суугчдыг эрчим хүч, мэдээллийн хэрэгслээр хангах асуудлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Энэ багц арга хэмжээн хөдөөгийн сууринг цахилгаан дамжуулах шугамд холбох, цөмийн болон нар, салхи, ус зэрэг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашигладаг тоног төхөөрөмж, мэдээллийн хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх асуудал хамарна;

4/аймаг, сум хоорондын зам харилцааг сайжруулах, сумдын төн хүртэл сайжруулсан замтай болгох, гүүр, гарц байгуулах, тариалан эрхэлдэг томоохон аж ахуйн нэгжийг төвтэй барагшун замаар холбох ажлыг үргэлжлүүлэн хийнэ. Орон нутгийн зам, гүүр барьж байгуулах, засвар хийх хөрөнгийн эх үүсвэр, зохион байгуулалтын ажлыг орон нутагт шийдвэрлэнэ;

5/хөдөөгийн сууринг газар нутгийн онцлог байдалд нн зохицуулан сансрын болон радиорелейн системээр холбоожуулах айл өрх, малчдын радио телевизийн нэвтрүүлэг хүлээн авах холбооны хэрэгсэл ашиглах боломжийг сайжруулна. Аймгаар сумдад, сумаас багт шуудангийн үйлчилгээг тогтмолжуулж хэвлэлийг орон нутагт хэвлэх замаар хүн амд түргэн хүргэх арг хэмжээ авна;

6/хөдөөгийн хүн амын соёлын түвшинг дээшлүүлэх, соёлын үйлчилгээг сайжруулахад онцлон анхаарч, хүүхэд залуучуудад үйлчлэх соёлын байгууллагыг өргөтгөж, үйл ажиллагааг нь хүн амын эн хэсгийн оюун санааны хэрэгцээг хангахуйц түвшинд хүргэхийг чухал гэж үзнэ;

7/хөдөөд боловсролын асуудлыг шийдвэрлэхдээ Бүх нийтэд суурь боловсрол эзэмшүүлэх болон Албан бус боловсролын үндэсний хөтөлбөр, сургуулийн өмнөх насны боловсролын хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх, сургууль завсардсан хүүхдэд боловсрол нөхөж олгох, насанд хүрэгчдийн боловсролын түвшинг дээшлүүлэх, хөдөөгийн сургуулиудын дотуур байрны хангамжийг сайжруулах, гэднийг үйлдвэрлэл, үйлчилгээ, туслах аж ахуй эрхлэхэд орон нутгийн захиргаанаас дэмжлэг үзүүлнэ;

8/эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламжийг хөдөөгийн хүн амд ойртуулахын хамт малчдын бага насны хүүхдийг урьдчилан сэргийлэх тарилгад тогтмол хамруулах, сумын эмнэлгийг түргэн тусламжийн машинаар хангах, бүх багуудыг бага эмчтэй болгох, тэдгээрийн тогтвортой ажиллах нөхцөл бүрдүүлж, уналга, зориулалтын үзэлийн байр, эмийн эргэлтийн сантай болгоно. Хөдөөд рашаан ус, эмийн ургамлын эмчилгээг өргөнөөр ашиглана;

9/хөдөөгийн хүн амын ундны болон ахуйн усны эх үүсвэрийг цэнгэгжүүлэх, шаардлага хангасан усаар үйлчлэх, усны чанарыг хянах нүүдлийн лаборатори бий болгохыг дэмжинэ;

10/хөдөөд орон сууц, монгол гэрийн тоноглолын үйлдвэрлэлийг орон нутагт нэмэгдүүлж, хэрэглэгчдэд ойр дөт нүүрсний ордыг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр ашиглуулах, шахмал түлшний үйлдвэрлэлийг дэмжинэ;

11/хөдөөгийн ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, ажлын байрны хангамж, нийгмийн эмзэг хэсгийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. Хөдөө аж ахуйн хөлсний хөдөлмөр эрхлэх, хөдөлмөрийг үнэлэх хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

III. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

1.Хөдөө аж ахуйн бодлого нь байгаль, хөрөнгө, хүн хүчний нөөцийг зөв хослуулан зохистой ашиглах замаар хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, түүний үр ашиг, бүтээгдэхүүний чанар, өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэн, өмчийн олон хэлбэрт тулгуурласан хөдөө аж ахуйн эрчимтэй, тогтвортой, үр ашигтай салбарыг бий болгон хөгжүүлэхэд оршино.

2.Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хөгжлийн загвар нь хот, суурингийн орчим болон дэд бүтэц бүхий газарт эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлж, алслагдсан нутагт бэлчээрийн уламжлалт мал аж ахуйг эрхлэх явдал мөн.

3.Хөдөө аж ахуйн үйл ажиллагааг байгаль хүн хоёрын бие биетэйгээ хоршин үйл бүтээх талбар хэмээн үзэж энэхүү үйл явцын эцэст аль нэг нь хохиролгүй байж хүмүүсийн амьжиргааны хэрэгцээг байнга хангах нь төрийн бодлогын зангилаа асуудал мөн. Байгалийн тэнцлийг алдагдуулахгүйгээр хөдөө аж ахуйн үйлдвэрлэл явуулахад шинжлэх ухааныг үндэс болгон ажиллахыг нийт хөдөө аж ахуйн салбарт хэвшүүлэх, энэ ажиллагааг төрийн зүгээс анхаарч зохицуулж байна.

4.Экологийн хувьд цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, оюуны багтаамж ихтэй, аз дүйлт багатай хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх явдлыг бүх талаар дэмжинэ.

Нэг. Мал аж ахуйн талвар

1.Бэлчээрийн уламжлалт мал аж ахуйн зэрэгцээ эрчимжсэн мал аж ахуй, тэжээл үйлдвэрлэлийг зохистой хослон хөгжүүлэх нь Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын баталгаа гэж үзнэ.

2.Монгол малын удмын сангийн үнэт чанарыг хадгалсан цөм, торгон сүрэг, гойд ашиг шимт малыг хамгаалан өсгөх үндсэн дээр нийт сүргийн чанарыг дээшлүүлэн малын генийн болон бүртгэл, мэдээллийн сан байгуулж ашиглана.

3.Иргэдийн малыг өсгөх, бэлчээр хамгаалах, сайжруулах, усжуулах, уст цэгүүдийг сэргээн тоноглох, тэдгээрийн барилга, тоног төхөөрөмжийг гэрээний үндсэн дээр айл өрхүүдийн дунд эзэмшүүлэн ашиглуулах буюу хувьчлах, ашиглагдаагүй газар нутгийг эзэмшин бэлчээрийн хүрэлцээг нэмэгдүүлэх замаар мал сүргийн тоо, бэлчээрийн даацын харьцааг зохистой хэмжээнд байлгана.

4.Монголын байгаль, цаг уурын нөхцөлд өсөн үржих чадвартай арвин ашиг шимтэй мал, амьтан тэдгээрийн үр, үр хөврөлийг улсын хилээр нэвтрүүлэхийг мэргэжлийн байгууллагын хяналт, баталгаатайгаар гүйцэтгэнэ. Гадаад орноос малын халдварт өвчин орж ирэхээс сэргийлж хилийн мал эмнэлгийн албыг бэхжүүлнэ. Аж ахуйн нэгжийн болон иргэдийн хувийн мал эмнэлгийн үйлчилгээг хөгжүүлэхийг дэмжихийн хамт малын халдварт өвчинтэй тэмцэх, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг төрөөс санхүүжүүлнэ.

5.Бэлчээрийн мал маллагаа, эмчилгээний уламжлалт аргу, технологийг баяжуулах, эм бэлдмэлийн үйлдвэрлэлийн техник технологийг сайжруулах, малын эм бэлдмэлийг дотооддоо үйлдвэрлэх бодлого баримтлана.

6.Бэлчээрийн мал аж ахуйд ажиллагсдын бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийг хөнгөвчлөн механикжуулах, цахилгаанжуулах, хөдөөгийн хөгжлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор

байгаль, цаг уурын нөхцөлд тохируулан үйлдвэрлэлийг төрөлжүүлэх, бусад салбартай зөв зохистой хослох, хорших зэрэг хөдөлмөр, үйлдвэрлэл, удирдлагын зохион байгуулалтын дэвшилтэт хэлбэрийг бүтээлчээр хэрэглэнэ.

Хоёр. Газар тариалангийн талаар

1. Үр тарианы үйлдвэрлэлийг хөрсний элэгдэл, эвдрэлээс хамгаалах технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлэн томоохон аж ахуйн нэгжээр, харин төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний үйлдвэрлэлийг жижиг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээр эрхлүүлэх замаар хэрэгцээгээ дотоодын үйлдвэрлэлээр хангах бодлого баримтална.

2. Байгаль, цаг уурын тааламжгүй нөхцөл үүсэж болох хомсдолын үед хэрэглэх улсын нөөцийн зориулалт бүхий буудай, түүний үр, өвс, тэжээлийн улсын сантай байна.

3. Газар ашиглалтыг сайжруулан үе залгамжилсан тариаланчидтай болох, тэдгээрийн үйлдвэрлэлээ явуулах болон ахуйн нөхцөлийг нь дээшлүүлэх, усалгаатай тариаланг хөгжүүлэх нь төрийн бодлогын нэг чиглэл мөн.

4. Монголын нөхцөлд зохицсон өндөр бүтээмжтэй, дотоодод засвар, үйлчилгээ хийх боломжтой, шатахуун хэмнэлттэй зарцуулаг, уян хатан ажиллагаатай техникийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх замаар хөдөө аж ахуйн техникийн паркийг шинэчлэх чиглэл баримтална. Хөдөө аж ахуйн техникт засвар, үйлчилгээ хийх, сэлбэг хэрэгсэл үйлдвэрлэх, худалдах чиглэлийн аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжинэ. Техник засварын газруудыг аж ахуйн нэгж болгох, эсхүл бэлтгэлийг хангасны үндсэн дээр хувьчлах арга хэмжээ авна.

5. Таримал урсгалын үрийн аж ахуйг зах зээлийн харилцааны гогтолцоонд зохицуулан зохион байгуулж төрийн дэмжлэг, хяналтад байлгана.

6. Хүн, мал, амьтан, байгаль орчинд сөрөг нөлөөгүй технологийг сэрэглэн бордоо үйлдвэрлэх, хэрэглэх, хог ургамал, өвчин, хөнөөлт цавьж, хөнөөлт мэрэгчтэй тэмцэх биологийн болон бусад арга хэмжээг төрийн хяналт, мэргэжлийн байгууллагын удирдлагын дор сэрэгжүүлнэ.

Гурав. Хүнсний хангамжийн талаар

1. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж тэдгээрийг иж бүрэн боловсруулахын зэрэгцээ мах, гурил, сүүн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг бүрэн хангах бодлого баримтална.

2. Жижиг, дунд үйлдвэрлэлийг түшиглэж мах, сүү боловсруулах үндэсний уламжлалт технологи нэвтрүүлэх ажлыг дэмжинэ.

3. Мах боловсруулах технологийг сайжруулж, экспортод гаргах мах, махан бүтээгдэхүүний боловсруулалт, чанарыг дэлхийн жишигт хүргэнэ. Хүнсний ногоо, жимс, жимсгэнийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах, бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, элсэн чихэр, ургамлын тос, зарим төрлийн будааг дотоодлоо үйлдвэрлэж хэрэгцээний зарим хэсгийг хангах зорилт тавьж хэрэгжүүлнэ.

4. Хүний биед бичил махбодийн дутагдал гарахаас сэргийлэх, хүүхдийн болон сувиллын зориулалттай хоол тэжээлээр хэрэглэгчдийг хангах асуудлыг төр анхааралдаа байлгаж, дээрх чиглэлийн үйлдвэрлэлийг дэмжинэ.

5. Холбогдох хууль тогтоомжийн дагуу хүнсний зүйлийн улсын нөөцийг бүрдүүлж нөхөн сэлбэж байна.

6. Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйлдвэрлэж, тээвэрлэж, хадгалж, худалдаж байгаа хүнсний зүйлийн чанар, аюулгүй байдлыг баталгаажуулж, түүнд тавих төрийн хяналтыг сайжруулна.

Дөрөв. Хөдөө аж ахуйн шинжлэх ухаан, боловсрол

1. Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний онол, арга зүй, удирдлагын түвшинг дээшлүүлж, биотехнологи, генийн инженерийн дэвшилтэт ололтыг бүтээлтээр нэвтрүүлэх замаар үйлдвэрлэлийг эрчимжүүлэн үр ашгийг дээшлүүлэх, экспортын бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэхэд эрдэм шинжилгээний байгууллагын үйл ажиллагааг чиглүүлнэ.

2. Хөдөө аж ахуйн эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн албаныг тоног төхөөрөмж, өндөр зэрэглэлтэй боловсон хүчнээр хангах, эрдэмтэн, багш нарын окууны үнэлгээг өндөржүүлэн өгөөж, чадавхийг нь үр бүтээлтэй ашиглах, эрдэм шинжилгээ, сургалт, үйлдвэрлэлийн хоршилт бий болгох арга хэмжээ авна.

3. Олон улсын түвшинд хүрсэн мэргэжлийн сургалт явуулах, төсөл, судалгаа, туршилтын ажлын захиалгыг үйлдвэрлэгчид буюу орон нутгаас авч гүйцэтгэх нь эрдэм шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны нэг хэлбэр байна.

4. Гадаад орнуудын зээл, тусламжийн хөрөнгийн зохих хэсгийг хөдөө аж ахуйн шинжлэх ухааныг хөгжүүлэх, зах зээлийн харилцааны нөхцөлд ажиллах мэргэжилтнүүдийг бэлтгэхэд зарцуулна.

5. Зах зээлийн нөхцөлд ажиллах мэргэжилтэн бэлтгэх, хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдийг давтан сургах, шинээр мэргэжил олгох, мэргэжлийн ажилчин бэлтгэх сургалт, богино хугацааны дамжааг зохион байгуулж ажиллуулна.

IV. ЗАХ ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИНГ БҮРДҮҮЛЭХ

1. Байгаль, цаг уур, улс орны эдийн засаг, гадаад, дотоод зах зээлийн тухайн нөхцөл, байдалтай уялдсан мөнгө, санхүү, худалдааны үр ашигтай уян хатан бодлогоор хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжин урамшуулахыг төрийн үүрэг гэж үзнэ.

2. Хөдөө аж ахуйд хувийн өмчийн чөлөөтэй хөгжих орчинг бүрдүүлэх зорилт тавина. Хөдөө дэх хувийн хэвшлийн аж ахуйн зонхилогч хэлбэр болж байгаа бэлчээрийн уламжлалт мал аж ахуй газар тариалан эрхэлдэг хувийн өмчтөний давамгайлах байр суурийг хадгална.

3. Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэртэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн төрийн өмчийг ойрын жилд багтаан хувьчилна.

4. Малчин өрх аж ахуйн нэгжийн аливаа хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.

5. Малчид, тариаланчид хөдөө аж ахуйн /гурил, сүүний гэх мэт/ үйлдвэрүүдийн хувьцаа эзэмших замаар үйлдвэрлэлийн эцсийн үр дүнг хуваалцах зохион байгуулалтын үр ашигтай бүтцийг бий болгох, эсхүл өөр хоорондоо хөрөнгө, хүчээ хоршиж жижиг, дунд үйлдвэр байгуулан ажиллаж зах зээлийн шударга өрсөлдөөнд оролцохыг дэмжинэ.

6. Үр тариа, махны хангамж, борлуулалтыг зохицуулах, тэдгээрийн үнэ тогтооход төрийн төв болон орон нутгийн байгууллагуудын шууд буюу шууд бус оролцоог зогсооно.

7. Хувийн аж ахуйтан өрх бие даан аж ахуйгаа эрхэлж, зах зээлд арилжаа хийх бололцоог бүрдүүлж, цаашид таваарын аж ахуй болон хөгжиж, аж ахуйн нэгжийн аливаа хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулах нөхцөлөөр хангахын зэрэгцээ газар нутгийн байршлаас хамаарч тэдний зах зээлд оролцоход хүндрэл гарч буйг харгалзан үйлдвэрлэл, үйлчилгээгээ хамтран эрхлэх, үйлчлэн зуучлах аж ахуйн нэгж үүсгэж бэхжүүлэхэд нь тусална.

8. Малчид, иргэдийн саналчилгаар бий болсон аж ахуйн нэгж нь гишүүдийнхээ үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг гэрээ, захиалгын дагуу зах зээлд борлуулах, хүнс, өргөн хэрэглээний бараа нийлүүлэх, ашигтай үйлдвэртэл, үйлчилгээг хослон эрхлэх, гишүүдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэрэг зорилгоо хангахын тулд дундайн сан, хөрөнгөө тасралтгүй арвижуулах, үнэт цаасны зах зээлд оролцох, олсон ашгийг гишүүдэд дахин хуваарилах зэрчмээр ажиллана. Хөдөө аж ахуйн үйлдвэртэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилготой холбоодыг дэмжиж хамтран ажиллана.

9. Сайн чанарын мал, таримал ургамлын үр, суулганы худалдааг аймаг, бүс нутаг, улсын хэмжээнд зохион байгуулахад бүх шатны Засаг даргын Тамгын газар, мэргэжлийн албад туслалцаа үзүүлнэ.

10. Гадаад зах зээлийн эрэлт, хэрэгцээг хангахуйц хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэж өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, түүний дотор сүү, цагаан идээ, мах, махан бүтээгдэхүүний боловсруулалт, тээвэрлэлтийн түвшинг сайжруулах, сав, баглаа, боодол, хөргөлт, зоорь, агуулахын аж ахуйг хөгжүүлэхийг дэмжинэ.

11. Малчид, тариаланчид төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалахад зориулж газар эзэмших, ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, үрээр хангах, мэргэжлийн сургалт явуулахад дэмжлэг үзүүлнэ.

12. Үйлдвэрлэгчдийг цаг тухайд нь техник, технологи, зах зээлийн болон үнийн зөв мэдээллээр хангах, шинэ техник, технологи эзэмшүүлэх, шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх боломж бүхий зохион байгуулалтын бүтцийг бий болгоно.

13. Аж ахуйн нэгжид хамрагдаагүй, хувийн аж ахуйтныг хоршиж ажил, үйлчилгээ, үйлдвэрлэл, борлуулалтаа хамтран зохион байгуулахад нь орон нутгийн захиргааны байгууллага байнга дэмжинэ.

14. Үр тариа, ялангуяа улаан буудайн үйлдвэрлэлийг урамшуулахын зэрэгцээ үр тарианы борлуулалтын ашиг, орлогоороо үйлдвэрлэлээ эрчимжүүлэх, өргөтгөх, ажлын байр шинээр бий болгох зэрэг арга хэмжээг төрөөс дэмжинэ.

15. Үйлдвэрлэл, хэрэглэгчдийн байршил, дэд бүтцийн хөгжлийн түвшин, байгаль, газар зүйн онцлогийг харгалзан эдийн засгийн бүсчлэл тогтоож, бүс нутаг хоорондын тэгш бус байдлыг зохицуулахад чиглэсэн татвар, рентийн ялгавартай бодлого явуулна.

16. Хөдөө аж ахуйн машин техник, сэлбэг, засварын зориулалттай тоног төхөөрөмж, бага оврын цахилгаан үүсгүүр, үр, суулгац, бордоо, малын эм бэлдмэл, үржлийн мал, амьтан импортлоход дэмжлэг үзүүлнэ.

17. Бэлчээр, хадлан, тариалангийн газрыг зохистой ашиглах, хамгаалах, усжуулах, сайжруулах зориулалт бүхий хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

18. Мал сүргийг гэнэтийн аюул, өвчнөөс урьдчилан сэргийлэх, ган, зуд, үер зэрэг цаг агаарын хүндрэлээс гарах хохирлыг нөхүүлэх давтгалын тогтолцоо бий болгоно. Байгаль, цаг уурын бэрхшээлээс урьдчилан сэргийлэхийн тулд өвс, хадлан бэлтгэх, хашаа саравч барих, тэжээл тариалах зэрэг ажлыг малчин өрхийн өөрийнх нь хүч бололцоонд тулгуурлан шийдвэрлэх чиглэл баримтална.

19. Эрүүл ахуйн, стандартын шаардлага хангасан хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлоход хууль зүйн болон

засаг захиргааны хориг, хязгаарлалт тавихгүй байх зарчмыг баримтална.

Ү. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

1.Төрөөс хөдөөгийн талаар баримтлах бодлого нь улс орны хөгжлийн стратегийн тодорхой үе шатуудыг хамран хэрэгжинэ.

2.Эхний үе нь 2000 он хүртэлх хугацааг хамрана. Энэ үе шатанд байгаль, техник, хүн хүч, хөрөнгийн байгаа нөөцөд тулгуурлан мал аж ахуйн үйлдвэрлэлийн хөгжлийг хангах, малчдын орлого, ашгийг нэмэгдүүлэх, хуримтлал бий болгох, газар тариалангийн үйлдвэрлэлийн уналтыг зогсоох, техникийн шинэчлэлт хийх суурийг бүрдүүлнэ. Тэгэхдээ нүүдлийн амьдралын хэв шинж зонхилсон хэвээр байна. Хөдөөгийн эрчим хүчний хангамжийг дээшлүүлэх асуудлыг тэргүүн ээлжинд шийдэхэд гол анхаарлаа төвлөрүүлнэ.

3.Хорин нэгдүгээр зууны эхний 10 жилд зөвхөн байгаа нөөцийг ашиглах төдийгүй хөдөлмөр, үйлдвэрлэлийг эрхлэх дэвшилтэт арга, технологийг хэрэглэх, оюуны хүч, бололцоо илүү шаардсан үйлдвэрлэлийг хөгжүүлэн түүний бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх замаар мал аж ахуйн үйлдвэрлэлийн цаашдын өсөлтийг эрчимжүүлэх, газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэн дотоодын хэрэгдээг хангах төдийгүй экспортын нөөцийг нэмэгдүүлэх болно. Эрчимжсэн үйлдвэрлэлийн тогтолцоог бий болгохын хэрээр малчид цагас суурьшлын байдалд шилжих нөхцөл аажмаар бүрэлдэнэ.

Хоёр мянган оноос хойшхи хугацаанд бэлчээрийн дацанд тохиуулан мал аж ахуйг эрхлэх дэвшилтэт арга нэвтрүүлэх, хөдөлмөр ороших, шинжлэх ухаан, техникийн дэвшлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх замаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрчимжсэн тогтолцоог үдхүү хөгжүүлж бүтээмж, үр ашиг, чанарын үзүүлэлтийн хувьд дэлхийн жишигт дүйцхүйц хөдөө аж ахуйн хүчирхэг салбар бий болгоно. Хөдөөгийн хот, тосгон, суурингийн тогтолцоо төлөвшиж энд оршин суугчид хангалуун амьдрах, эрүүл аж төрөх, соёлын алаар боловсрон хөгжих таатай орчин бүрдэнэ. Дэлхийн хөгжлийн рөнхий зүй тогтолд нийцсэн Монгол орны онцлогтой зүй зохистой осолсон амьдралын өвөрмөц хэв шинжийг бий болгоно.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 5 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 33

Улаанбаатар
хот

**Улсын төвлөрсөн төсвийн 1995 оны
гүйцэтгэлийг батлах тухай**

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: Монгол Улсын 1995 оны улсын төвлөрсөн төсвийн орлогын гүйцэтгэлийг 113291451,0 мянган төгрөгөөр, зарлагын гүйцэтгэлийг 119393518,2 мянган төгрөгөөр баталсугай.

Дарга

Н.БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 5 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 34

Улаанбаатар
хот

**Монголбанкны жилийн тайлан тэнцэл
ашгийн хуваарилалтыг батлах тухай**

Монголбанкны 1995 оны тайлан тэнцлийг хэлэлцээд Монгол Улсын Банкны хуулийн 21,26 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монголбанкны 1995 оны санхүүгийн жилийн тайлан тэнцлийн 1995 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдлийг 192,052,131,209 төгрөг 45 мөнгө, ашгийг 676,025,067 төгрөг 02 мөнгөөр тус тус баталсугай.

2. Монголбанкны 1995 оны ашгийг дор дурьдсанаар хуваарилсугай:

а/ нөөцийн санд	70,000,000 төгрөг
б/ улсын төвлөрсөн төсөвт	200,000,000 төгрөг
в/ нийгмийн хөгжлийн санд	106,025,067 төгрөг 02 мөнгө
г/ Моснарбанкинд төлөх өрийн эх үүсвэрт	300,000,000 төгрөг

Дарга

Н.БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 5 дугаар
арын 21-ний өдөр

Дугаар 35

Улаанбаатар
хот

**Төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийг
хэлэлцсэн тухай**

Монгол Улсын 1995 оны улсын төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийг элэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын 1995 оны улсын төвлөрсөн төсвийн хуулиар атлагдсан төсвийг хэтрүүлж зарцуулсан төр, захиргалмы айгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтын байдал болон улсын өвлөрсөн төсвөөс Хилийн цэргийн удирдах газарт 1995 онд өрөнгө оруулалтын зориулалтаар олгосон 100 сая төгрөгийн ндэслэл, тооцоо материалыг магадлан шалгаж зохих арга хэмжээг чиглүүлэн энэ оны 10 дугаар сард багтаан Улсын Их Хуралд танилцуулахыг Төрийн хянан шалгах хороонд даалгасугай.

арга

Н.БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 5 дугаар
арын 21-ний өдөр

Дугаар 36

Улаанбаатар
хот

**Санал шүүмжлэлийн мөрөөр зохих
ажлын тухай**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монголбанкны 1995 оны тайлан тэнцэл, алшгийн хуваарилалт элэн Монголбанкинд хийсэн шалгалтын дүнг Улсын Их Хурлын айнгын хороогоор хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүдээс иргэсэн санал, дүгнэлт, банкны үйл ажиллагааны талаар илгүүллага аж ахуйн нэгж, хөдөлмөрдөөс гаргаж байгаа үүмжлэлийг Монголбанкны Ерөнхийлөгчийн зөвлөлөөр авч элэлцэн дүнг 1996 оны 10 дугаар сард Улсын Их Хуралд илтгэхийг Монголбанк /Д.Моломжамц/-д даалгасугай.

2.Банкны системийн бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх албыг 1996 оны батлагдсан төсөвтөө багтаан байгуулж ажиллуулахыг Монголбанк /Д.Моломжамц/-д зөвшөөрсүгэй.

Дарга

Н.БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 5 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 37

Улаанбаатар
хот

**Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим
албан хаагчийн албан тушаалын
цалингийн тухай**

Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаа **ТОГТООХ нь:**

1."Төрийн улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн болон албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийн хэмжээг тогтоох тухай" Улсын Их Хурлыг 1995 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 65 дугаар тогтоолыг хавсралтын "Дүүргийн Засаг дарга, Сумын Засаг дарга, Хорооны Засаг дарга, Багийн Засаг дарга" гэснийг 1996 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

2."Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 1996 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуульд заасны дагуу тогтоол, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргын цалинг 1996 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нөхөн олгохыг Засгийн газар зөвшөөрсүгэй.

Дарга

Н.БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 8 дугаар
сарын 1-ний өдөр

Дугаар 27

Улаанбаатар
хот

**Засгийн газрын гишүүн байсан зарим
хүмүүсийн хангамжийн тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5-д заасныг үндэслэн Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Засгийн газрын гишүүнээр ажиллаж байсан Ч.Пүрэндорж, Л.Энэбиш, З.Батжаргал, Ш.Жадамбаа, Ц.Гомбосүрэн, Э.Бямбажав, Б.Жигжид, Э.Гомбожав, Ц.Өөлд Ц.Цогт, Н.Лувсанжав, Н.Энхбаяр, П.Нямдаваа нарт Улсын Их Хурлын 1995 оны 65 дугаар тогтоолоор тогтоосон цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг 1996 оныг дуусгал сар бүр олгож байхаар тогтоосугай.

2. Энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан Засгийн газрын гишүүн байсан хүмүүсийг дурдсан хугацааны дотор тодорхой ажил, албан тушаал эрхлүүлэх талаар холбогдох арга хэмжээ авахын зэрэгцээ томилогдсон ажил, албан тушаалын цалин хөлс Засгийн газрын гишүүнийхээс бага байвал зөрүүг тооцож олгохыг Засгийн газарт даалгасугай.

Дарга

Р.ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 8 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 28

Улаанбаатар
хот

Комисс байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Монголын тулгар төрийг үүсгэн байгуулсны 790 жилийн ойг гохиолдуулан өршөөл үзүүлэх комиссыг дор дурьдсан бүрэлдэхүүнгэй байгуулсугай:

Комиссын дарга:

С.Батчулуун

-Хууль зүйн байнгын хорооны дарга

Орлогч дарга:

Д.Сугар -Хууль зүйн яамны төрийн нарийн бичгийн дарга

Нарийн бичгийн дарга:

Л.Гарамжил -Хорих байгууллагуудыг удирдах газрын дарга

Гишүүд:

Д.Батнасан -Улсын Их Хурлын гишүүн

О.Энхтуяа -Улсын Их Хурлын гишүүн

Б.Цэрэндорж -Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх

Ч.Ганбат -Улсын Дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгч

О.Баяраа -Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор

П.Ганбаатар -Нийслэлийн Засаг даргын орлогч

О.Шагдарсүрэн -Эрүүгийн цагдаагийн газрын дарга

А.Зангал -Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн дарга

Р.Бат-Эрдэнэ -Гэгээрлийн яамны төрийн нарийн бичгийн дарга

Ц.Цэцэгмаа -Ерөнхийлөгчийн тамгын газрын ажилтан

Л.Рэнчин -Монголын өмгөөлөгчдийн холбооны дэд ерөнхийлөгч

2.Комисст даалгах нь:

а/ Монголын тулгар төрийг үүсгэн байгуулсны 790 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх ажлыг Монгол Улсын хуулийн дагуу 1996 оны 9 дүгээр сарын 26-ны дотор багтаан гүйцэтгэж дүнг Улсын Их Хуралд танилцуулах;

б/ Өршөөл үзүүлэх тухай хуулийг бүх ялганд тайлбарлан таниулах, хорих газраас суллагдаж байгаа хүмүүсийг орон нутагт хүргэх ажлыг шуурхай зохион байгуулах.

3.Хорих газраас сулагдсан хүмүүсийг орон нутагт хүргэх болон өршөөл үзүүлэхтэй холбогдсон зардлыг Улсын төсвөөс гаргахыг Сангийн сайд /П.Цагаан/-д зөвшөөрсүгтэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 8 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар
хот

"Залуучуудын өдөр" бий болгох тухай

Монгол орны хүн амын олонхи болсон залуучуудын асуудалд төр, олон нийтийн анхаарлыг хандуулж, залуучуудын санал санаачлагыг дэмжиж Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Жил бүрийн 8 дугаар сарын 25-ны өдрийг "Залуучуудын өдөр" болгон улс даяар тэмдэглэж байхаар тогтоосугай.

Дарга

Р.ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 8 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 31

Улаанбаатар
хот

Ажилд томилгох тухай

Монгол Улсын Банкны хуулийн 9 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Жигжидийн Үнэнбатыг Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр, Магваны Болдыг Монголбанкны дэд ерөнхийлөгчөөр тус тус томилсугай.

Дарга

Р.ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

1996 оны 8 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 33

Улаанбаатар
хот

**Хэлмэгдэгсдийн дурсгалын өдөр
бий болгох тухай**

Улс төрийн хилс хэрэгт олон мянган иргэдийг хилсээр хэлмэгдүүлсний төлөө Монголын төр ард түмнээсээ уучлал хүсэж, амь насаа алдсан хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэн мөнхжүүлэх, санан дурсах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улс төрийн хэлмэгдүүлэлт өргөн хүрээтэй нийтийг хамарч өрнөсөн 1937 оны 9 дүгээр сарын 10-ны өдрөөр төлөөлүүлэн жил бүрийн Есдүгээр сарын 10-ны өдрийг "Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалын өдөр" болгон улс даяар тэмдэглэж байхаар тогтоосугай.

2. "Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалын өдөр"-өөр хүндэтгэл, ёслолын арга хэмжээ зохиох, түүнд төр, засгийн байгууллага, албан тушаалтан, олон нийтийг өргөн хамруулах талаар идэвхтэй ажиллахыг Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс, түүний харьяа орон нутгийн салбар комиссуудад даалгасугай.

Дарга

Р. ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 7 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 148

Улаанбаатар
хот

**Б. Цэдэвт Монгол Улсын аж
үйлдвэрийн гавьяат ажилтан
цол олгох тухай**

Хүнсний үйлдвэрийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж зах зээлийн эдийн засгийн шилжилтийн үед үйлдвэрлэлийн жигд ажиллагааг ханган, бүтээгдэхүүний чанар, үр ашгийг дээшлүүлэх, ажиллагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар санаачилга гарган хэрэгжүүлж, улс орны болон нийслэлчүүдийн гурилын хэрэгцээг хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Алтан тариа" хувыцаат компанийн гүйцэтгэх захирал Барамсайн Цэдэвт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П.ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 7 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 149

Улаанбаатар
хот

**Г. Чадраабалд Монгол Улсын
гавьяат мал зүйч цол олгох
тухай**

Хөдөө аж ахуйн эрдэм шинжилгээний байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж ширүүвтэр ноост хонины үржлийн бааз бий болгох, нарийвтар ноост, махны хэвшлийн "Ерөө" хонийг гаргах, хонины нийт үүлдэр, үүлдрийн хэсгийг баталгаажуулах зэргээр хонины аж ахуйг хөгжүүлэх болон бэлчээрийн мал аж ахуйн уламжлалын шинжлэх ухааны үндэслэл тогтооход оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Мал аж ахуйн эрдэм шинжилгээний

хүрээлэнгийн зөвлөх Гэндэнгийн Чадраабалд Монгол Улсын гавьяат мал зүйч цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П.ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 7 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 150

Улаанбаатар
хот

**Д. Мятагт Монгол Улсын гавьяат
багш цол олгох тухай**

Ерөнхий боловсролын сургуульд бага ангийн багшаар олон жил үр бүтээлтэй ажиллаж хүүхдийн авьяас сонирхлыг багас нь нээн илрүүлж хөгжүүлэн, бага ангийн сургалтын өөрийн өвөрмөц арга барил бий болгож, дээд ангийн сурагчдыг сүүлийн найман жил дараалан зуун хувь сайн, онц дүнтэй сургасан өндөр амжилтыг нь үнэлж Дархан-Уул аймгийн 10 жилийн 9 дүгээр дунд сургуулийн багш Дэмчигийн Мятагт Монгол Улсын гавьяат багш цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П.ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 7 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 151

Улаанбаатар
хот

**Р. Оюунбадамд Монгол Улсын гавьяат
хуульч цол олгох тухай**

Хорих байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, хориглол ял эдлүүлэн үйлдсэн хэрэгт нь гэмшүүлэх, тэдний дунд хууль ёс, дэ журмыг сахиулж дахин гэмт хэрэг хийхээс сэргийлэх үүргээ чанд

биелүүлж, хоригдлын ахуй хангалт, хөдөлмөр эрхлэлтийг оновчтой зохион байгуулан хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Эмэгтэйчүүдийн хорих ангийн дарга Роломсүрэнгийн Оюунбадамд Монгол Улсын гавьяат хуульч цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П.ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

1996 оны 7 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 152

Улаанбаатар
хот

**Ж.Биндэрьяад Монгол Улсын
гавьяат эмч цол олгох тухай**

Эрүүл мэндийн салбарт үр бүтээлтэй ажиллаж хэвлийн хөндийн сури үрөвсэлт өвчин, ясны архаг үрэвслийг мэргэжлийн өндөр гөвшинд мэс заслаар эмслэн олон арван хүнийг эрүүлжүүлэн хүн имын эрүүл мэндийг хамгаалах үйл хэрэгт оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Завхан аймгийн нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн эрхлэгч, их эмч Жүгдэрийн Биндэрьяад Монгол Улсын гүний гавьяат эмч цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П.ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ

1996 оны 7 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 153

Улаанбаатар
хот

С. Вандан, Д. Дуламсүрэн нарт
Монгол улсын гавьяат жүжигчин
цол олгох тухай

Урлаг соёлын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж Монгол Улсын соёл урлагт өөрийн гэсэн өвөрмөц өнгө аястай дуу хөгжмийн гэр бүлийн цөөхүүл хамтлагийг шинээр бий болгон, өргөн олон түмнийг хамран үйлчилж, авьяас билгээрээ үзэгчдийн сонирхлыг татаж, хөдөлмөрийн өндөр амжилт гаргаж байгаа Төв аймгийн Хөгжимт жүжгийн театрын гоцлол дуучин Сэр-Одын Вандан, Дэмбэрэлийн Дуламсүрэн нарт Монгол Улсын гавьяат жүжигчин цол тус тус олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

П.ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН
ХУУЛИЙН ЦЭЦИЙН
ТОГТООЛ**

996 оны 6 дугаар
арын 19-ний өдөр

Дугаар 2

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн
хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
хуулийн 1 дүгээр зүйлийн 5 дахь
хэсгийн зарим заалт Үндсэн хууль
зөрчсөн тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн бүх гишүүдийн хуралдааныг Цэцийн дарга Г.Совд даргалж, гишүүн Л.Баасан, Н.Жанцан, С.Бямба, С.Жанцан, Д.Чилхалажав, Ж.Бямбажав нарын бүрэлдэгчтэй нарийн бичгийн даргаар Ж.Баттуяаг оролцуулан хийв.

Цэцийн хуралдаанаар иргэн Д. Чулуунжавын гомдлоор үүссэн улсын Их Хурлын Сонгуулийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчиж ялгаа эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэхээр хэлэлцэв.

Цэцийн хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн С. Батмөнх оролцов.

Өргөдөл гаргасан иргэн Д. Чулуунжав Ховд аймагт сонгуулийн импанит ажлаар ажиллаж байгаа бөгөөд хурлын товыг мэдэгдсэн словч ирж амжихгүй, хуралдааныг өөрийнхөө оролцоогүйгээр йхийг зөвшөөрч утсаар мэдэгдсэн болно.

Иргэн Д.Чулуунжав Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөл, нэмэлт тайлбартаа:

Нэр дэвшсэн хүмүүсээс хэнийг нь ч сонгох хүсэлгүй иргэдийн налыг хүчингүйд тооцох нь тэр хүний сонгуулийн эрхийг цэсантай ижил юм.

Татгалзсан саналыг хүчингүй хуудсанд тооцож хасаад байвал нэрвшигчийн авсан саналын хувь хэмжээ зохиомлоор өсөх болно. Ингуульд оролцсон л бол заавал хэн нэг хүний төлөө саналаа өгөх гой гэж сонгогчийг шахаж болохгүй. Үндсэн хуульд заасан өлөөтэй" гэдэг зарчмын нэг тал нь сонгох ба эс сонгох эрх чөлөө ч билээ. Ингэхлээр бүрэн татгалзсан саналыг хүчингүйд тооцсон улсын талаар ул үндэстэй дахин бодож үзээд түүнийг хүчинтэйд эцэхоор хуульчилж Улсын Их Хурлын сонгуулийн хуульд рчлөлт оруулж өгөхийг хүсье. Бүх нэр дэвшигчийн хувьд талзсан санал өгч болохгүй гэх юм уу, эсвэл заавал хэн нэгийг нь

дэмжиж санал өг гэж сонгогчийг шахаж болохгүй. Ингэхлээр 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт байгаа санал огт тэмдэглээгүй хуудсыг хүчингүйд тооцох тухай заалт сонгогчийн сонгох ба эс сонгох эрх Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заагдсан сонгогчийн чөлөөтэй сонголт хийх эрхийг зөрчиж байна гэж дурджээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаас:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт өөрчлө оруулах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн "Санал огт тэмдэглээгүй бол ... саналын хуудсыг хүчингүйд тооцно" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчиж гэсэн 03 тоот дүгнэлт гаргасан байна.

Үндсэн хуулийн цэцийн энэхүү дүгнэлтийг авч хэлэлцээд Улсын Их Хурлын 1996 оны 5 дугаар сарын 28-ны өдөр гаргасан 41 дүгээр тогтоолд Улсын Их Хурлын Сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлө оруулах тухай 1996 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулийг зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байна гэж Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн тоот дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзжээ.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн С. Батмөнх Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа Улсын Их Хурлын сонгуулийн хуульд эс сонгох тухай асуудлыг хөндөөгүй болно. Ер нь ч сонгох, сонгогдох эрхийн асуудлыг үйлдэл, эс үйлдэлтэй адилтган үнэмлэхүй утгаар авч үздэгт практик байдаг.

Санал огт тэмдэглээгүй хуудсыг хүчинтэй хуудсанд тооцож санал хураалтыг будлиантуулах, сонгууль олон газар дахин явагдсан нэр дэвшигчдийн төлөө өгсөн саналын эзлэх хувийг зохиомлоо бууруулах болно.

Цэцийн 03 тоот дүгнэлтэд дурдсан санал огт тэмдэглээгүй гэж бол иргэдийн сонгох эрхийг хөндсөн зарчмын асуудал биш. Гагцхөн санал тоолох аргачлалыг л тодорхойлсон техник ажлын чанартаа санаа тул энэ заалт Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлт үндэслэлтэй гэж зарим гишүүд үзсэн гэжээ.

ХЯНАВАЛ:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлө оруулах тухай 1996 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн "Санал огт тэмдэглээгүй буюу" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "чөлөөт" гэсэн сонгуулийн зарчмыг зөрчиж иргэдийн сонгох, эс сонгох эрхийг хязгаарласан

айна. Энэ талаар гарсан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1996 оны 5 дугаар сарын 23-ны 03 тоот дүгнэлтийг хүлээн ившөөрөөгүй Монгол Улсын Их Хурлын 1996 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 41 дүгээр тогтоол хууль зүйн үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 3,4 Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн гишүүдийн хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйлийн дахь хэсгийн заалтаар өөрчлөлт оруулсан Монгол Улсын Их урлын Сонгуулийн хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн Санал огт тэмдэглээгүй буюу" гэсэн заалтыг хүчингүй болгосугай.

2. Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийн тухай Монгол Улсын Их урлын 1996 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 41 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэ тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр хно.

Дарга
Гишүүд

Г.СОВД
Л.БААСАН
Н.ЖАНЦАН
Ж.БЯМБА
С.ЖАНЦАН
Д.ЧИЛХААЖАВ
Ж.БЯМБАЖАВ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1996 оны 3 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 57

Улаанбаатар
хот

Стандарт, чанар, хэмжилтүйн улсын
хяналтын дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Стандарт, чанарын улсын хяналтын дүрэм"-ийг 1 дүгээр хавсралтын, "Хэмжилтүйн улсын хяналтын дүрэм"-ийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталеугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П.ЖАСРАЙ

Монгол Улсын сайд бөгөөд Үндэсний хөгжлийн газрын дарга

Ч.УЛААН

Засгийн газрын 1996 оны 57 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

СТАНДАРТ, ЧАНАРЫН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.Стандарт, чанарын улсын хяналтын зорилт нь Монгол Улсын хэмжээнд байгууллага, аж ахуйн нэгжийн харьмалал, өмчийн төрөл хэлбэрийг харгалзахгүйгээр Монгол улсын стандартчилал, чанарыг баталгаажуулалтын тухай хууль болон хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаархи хууль тогтоомж, тэдгээрийг үндэслэн эрх бүхи байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангуулахад оршинс.

2.Стандарт, чанарын улсын хяналтыг стандарт, чанарын улсын хяналтын газар /цаашид "алба" гэх/, аймаг, нийслэлийн стандарт чанарын хяналтын улсын байцаагчид хэрэгжүүлнэ.

3.Стандарт, чанарын улсын хяналтын албаны дарга нь стандарт чанарын хяналтын улсын ерөнхий байцаагч байна. Стандарт чанарын хяналтын улсын ерөнхий байцаагчийг стандартчиллын

асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд томилж, чөлөөлөх бөгөөд улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газраас олгоно.

4.Стандарт, чанарын улсын хяналтын албаны улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг стандарт, чанарын хяналтын улсын ерөнхий байцаагчийн санал болгосноор стандартчиллын асуудал эрхэлсэн сайд томилж, чөлөөлнө.Аймаг, нийслэлд ажиллах стандарт, чанарын хяналтын улсын байцаагчийг аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлөх бөгөөд улсын байцаагчийн эрхийг стандартчиллын асуудал эрхэлсэн сайд олгоно.

5.Ажил төрлийн онцлог байдлаас зарим яам, тусгай газарт стандарт, чанарын хяналтын улсын байцаагч ажиллуулж болно. Яам, тусгай газарт ажиллах улсын байцаагчийг сайд, дарга нар нь томилж, чөлөөлөх бөгөөд тэдгээр байцаагчийн эрхийг стандартчиллын асуудал эрхэлсэн сайд олгоно.

6.Стандарт, чанарын хяналтыг хэрэгжүүлэхэд хөдөлмөрийн нөхцөл, хүн, малын эмнэлэг, эм, биобэлдмэл, эрүүл ахуй, байгаль орчин, мал, амьтны үржил, үр, ургамал хамгаалал, эрчим хүч, уул уурхай, барилга, тээвэр, холбоо, худалдааны зэрэг захиргааны хяналтын албад оролцох бөгөөд энэ талаархи үйл ажиллагааг стандарт, чанарын хяналтын улсын ерөнхий байцаагч зохицуулна.

7.Стандарт, чанарын хяналтын улсын байцаагчид нь стандарт, чанарын асуудлаар мэргэшсэн байна.

8.Стандарт, чанарын улсын хяналтын алба, стандарт, чанарын хяналтын улсын байцаагчид нь үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, тэдгээрийг үндэслэн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон дүрэм, журам болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

9.Стандарт, чанарын хяналтын улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч, улсын байцаагч /шашид энэ дүрэмд "Улсын байцаагч" гэх/ нь Засгийн газраас загварыг нь баталсан үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг болон албан шаардлага, акт, торгууль, шийтгэврийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

10.Аймаг, нийслэлд болон яам, газарт ажиллаж байгаа стандарт, чанарын хяналтын байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, мэргэжлийг дээшлүүлэх, эрх авсан лабораторийн үйл ажиллагаа, байцаагчдын ажлыг шалгах, шалгалтын дүнг нэгтгэн дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлаар авах арга хэмжээний санал боловсруулж шийдвэрлүүлэхийг стандарт, чанарын улсын хяналтын алба хариуцан хэрэгжүүлнэ.

Хоёр.Стандарт, чанарын улсын хяналтын чиглэл

11.Стандарт, чанарын улсын хяналтыг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ:

а/стандарт, чанарын талаархи хууль тогтоомж болон түүнийг үндэслэн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журмын хэрэгжилт;

б/манай улс гишүүнээр элсч нэгдэн орсон олон улсын эрх бүхий байгууллагаас баталж, нийтлэг мөрдөж байгаа болон хоёр талын байгуулсан стандарт, чанарын холбогдолтой конвенци, гэрээ эрх зүйн бусад баримт бичгүүдийн биелэлт;

в/хүн, мал, амьтан, байгаль орчинд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүний болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны чиглэлээр батлагдсан заавал мөрдөх улсын стандартын үзүүлэлт шаардлагын мөрдөлтийг тэдгээрийн зураг төслийг зохион бүтээх, үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, борлуулах, хэрэглэх болон хаягдал ашиглах үе шатыг хамруулан хяналт тавих;

г/аж ахуйн нэгж, байгууллага нь бүтээгдэхүүн, үйлчилгээндээ олон улс, бүс нутаг, гадаад улсын дэвшилтэт стандартыг мөрдөх тохиолдолд тэдгээрийг зохиох журмын дагуу бүртгүүлэн хэрэглэж байгаа эсэх;

д/шинэ технологи эзэмшин, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүний чанар, аюулгүйн үзүүлэлт шаардлага нь Монгол Улсад хэрэглэхээр заасан ади төстэй бүтээгдэхүүний үзүүлэлт шаардлагаас өөр байх тохиолдолд стандартчилал, баталгаажуулалтын төв, орон нутгийн байгууллагаас түр зөвшөөрөл авсан эсэх;

е/аж ахуйн нэгж, байгууллага нь улсын буюу байгууллагын стандартгүйгээр бүтээгдэхүүнийг бөөнөөр үйлдвэрлэх буюу эсвэл хүчин төгөлдөр бус стандарт хэрэглэж байгаа эсэх;

ж/аж ахуйн нэгж, байгууллага нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүндээ стандартын тэмдэглэгээг зөв хэрэглэсэн эсэх;

з/аж ахуйн нэгж, байгууллага нь хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй бүтээгдэхүүн болон экспорт, импортын бүтээгдэхүүнийг чанарын баталгаажуулалтад хамруулсан байдал;

и/чанарын гэрчилгээ, тохирлын тэмдэг хэрэглэх эрх авсан байгууллага, аж ахуйн нэгжийн эрхийг нь олгосон байгууллагатай хийсэн гэрээний биелэлтийн байдал;

к/бүтээгдэхүүний чанарын тодорхой үзүүлэлтийг сорьж турших чиглэлээр итгэмжлэл хүлээж, эрх авсан сорилтын лабораториудын дүрмийн болон гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт;

л/экспортын бүтээгдэхүүнд чанарын гэрчилгээ, импортын бүтээгдэхүүнд худалдан борлуулах зөвшөөрөл олгох журмын мөрдөлт;

м/аж ахуйн нэгж, байгууллагын заавал мөрдөх улсын

стандарт бүхий бүтээгдэхүүний чанарын ангилал, зэрэглэл нь үнэн зөв тогтоогдсон эсэх;

н/аж ахуйн нэгж, байгууллагын бөөнөөр үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний заавал мөрдөх улсын стандартын чанар, аюулгүй байдлын үзүүлэлт шаардлагын мөрдөлт, чанарын баталгаажуулалтын байдал;

о/импортын бүтээгдэхүүний хаяглалт, шонголголт, халгалалт, гээвэрлэлтийн нөхцөлд тавигдах үзүүлэлт, шаардлагын хэрэгжилт;

п/бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний зориулалт, хэрэглээний чанар, аюулгүй байдал, халгалах, хэрэглэх аргын талаар аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэглэгчдэд үнэн зөв мэдээлэл өгч байгаа эсэх.

Гурав. Стандарт, чанарын хяналтын улсын байцаагчийн үүрэг, эрх

12. Улсын байцаагч дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а/энэ дүрмийн 11 дүгээр зүйлд заасан чиглэлийн дагуу улсын хяналтыг зохион байгуулж хэрэгжүүлэх;

б/байцаагч нь бусдын нөлөөнд үл автан, албан үүргээ шуударгаар биелүүлд, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, технологийн үйлчилгээгээ хяналтаар холбоотой нууцыг халгалж, хяналт, шалгалтыг бүрэн үйцэд хийх;

в/хийсэн хяналт, шалгалт, гартсан дүгнэлт, тавьсан акт, оргууль, шийтгэвэр, албан шаардлагынхаа үнэн зөвийг бүрэн ариуцах;

г/хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, асран зогсоох, гарч болзошгүй зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

13. Улсын байцаагч нь дор дурдсан эрх эзлэнэ:

а/хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, тасан зогсоох талаар аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, холбогдох хүмүүст шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах;

б/холбогдох байгууллагатай нь тохиролцсоноор зохих мэргэжлийн хүмүүсийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулах, шаардлагатай асуудлыг магадлах зорилгоор сорилт шинжилгээг эрх бүхий байгууллагын итгэмжтэгдсэн лабораториор гүйцэтгүүлэх;

в/шинжилгээнд шаардагдах бүтээгдэхүүний дээж, загвараас өмдэглэл үйлдэн холбогдох стандартад заасан тоо хэмжээгээр үнэ мэдээлэл өгч, элбөргүй авах;

г/шалгалтад шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, магадлал, үндэслэл баримт нотолгоог тухайн аж ахуйн нэгж, байгууллага, албан

тушаалтан, холбогдох хүмүүсээс үнэ төлбөргүй гаргуулан авах;

д/шаардалагатай үед өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээний болон агуулах, бусад ажлын байранд үзлэг шалгалт явуулах;

е/хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтан шууд буюу шууд бусаар хор хохирол учруулж байгаа болон учруулж болох, түүнчлэн осол аюултай болох нь батлагдсан, чанар, хэрэг лээний шаардлага хангахгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэж нийлүүлсэн хүлээн авсан, худалдсан, импортлосон, ажил үйлчилгээ гүйцэтгэсэн, улсын стандартад тохирохгүй эрүүл ахуйн болон хөдөлмөрийн нөхцөлд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсэн тохиолдолд тухайн үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг уг зөрчлийг арилгах хүртэ хүхэлд нь, эсвэл хэсэгчлэн түр зогсоох, бараа бүтээгдэхүүний борлуулахыг хориглон битүүмжлэх, шаардалагатай гэж үзвэл устгах өөр зориулалтаар ашиглах шийдвэр гаргах, энэ тухай олон нийтэ зарлан мэдээлж сэрэмжлүүлэх;

ж/заавал мөрдөх улсын стандартгүйгээр бөөнөөр үйлдвэрлэ явуулах, эсвэл хүчин төгөлдөр бус стандарт хэрэглэх болон заава мөрдөх улсын стандартыг зөрчиж үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахы хориглож, холбогдох арга хэмжээг авах хүртэл үйлдвэрлэл үйлчил гээг түр хугацаагаар зогсоох;

з/стандарт, чанарын талаар удаа дараа зөрчил гаргаж, тэр н эрүүгийн шинж чанартай болсон байвал холбогдох материалы бүрдүүлж хуулийн байгууллагад шилжүүлэх.

14.Стандарт, чанарын хяналтын улсын байцаагч нь хууль тог тоомж, дүрэм, журам зөрчсөн, тавьсан албан шаардлагыг бие лүүлээгүй гэм буруутай этгээдэд Монгол Улсын Төрийн хянал шалгалтын, Стандартчилал, чанарын баталгаажуулалтын, Хүнсний Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, Захиргааны хариуцлагын, Хэмж лийн нэгдмэл байдлыг хангах, Архидан согтуурахтай тэмцэх туха хуулиуд болон холбогдох бусад хуулийн заалтыг үндэслэн дараах захиргааны хариуцлага хүлээлгэнэ:

а/Стандартчилал, баталгаажуулалтын төв болон түүнээс чана рын баталгаажуулалт хийх эрх авсан байгууллагын холбогдох алба тушаалтан стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуул тогтоомж зөрчиж үйл ажиллагаагаа явуулсан, шийдвэр гаргасан бо 5000-15000 төгрөгөөр торгох;

б/стандарт, чанарын төрийн захиргааны хяналтыг хэрэгжүү лэхэд шаардагдах мэдээ, мэдүүлгийг хуурамчаар гаргасан, стандарт чанарын хяналтын улсын байцаагчаас өгсөн үүргийг хугацаанд н биелүүлээгүй албан тушаалтныг 30000-150000, иргэнийг 20000-5000 төгрөгөөр торгох;

в/итгэмжлэгдсэн лаборатори нь сорилтын дүн, дүгнэлтийг зориуд буруу гаргасан, үүргээ биелүүлээгүй, эрхээ хэтрүүлсэн, эсхүл холбогдох стандарт, норматив-техникийн баримт бичгийг зөрчиж үйл ажиллагаагаа явуулсан бол 50000-100000 төгрөгөөр торгох;

г/бүтээгдэхүүний харилцан орлолт, хэмжлийн болон мэдээллийн нэгдмэл, үнэн зөв байдлын хангалт, зохион байгуулалт, арга зүйн нийтлэг шаардлага, байгаль орчны төлөв байдлыг болон бүтээгдэхүүн, хөдөлмөрийн нөхцөлийг шалгах, сорих, шинжлэх, цэмжих аргын УСТ-ыг зөрчсөн, аж ахуйн нэгж, байгууллага нь сүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй болон экспорт, импортын бүтээгдэхүүнийг чанарын баталгаажуулалтад хамруулаагүй бол зөрчил гаргасан аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000, иргэнийг 5000-15000 төгрөгөөр торгох;

д/эдийн засаг, нийгмийн чухал ач холбогдол бүхий бүтээгдэхүүний заавал мөрдөх улсын стандартын үзүүлэлт шаардлагыг зөрчсөн, эсхүл улсын буюу байгууллагын стандартгүйгээр бүтээгдэхүүнийг бөөнөөр үйлдвэртэх, хүчин төгөлдөр бус стандарт хэрэглэх, стандартын үзүүлэлт шаардлага хангаагүй бүтээгдэхүүнд стандартын тэмдэглэгээ хэрэглэсэн, бараа бүтээгдэхүүний чанарын ангилал, гэрэглэлийг зориуд өсгөсөн, улсын стандартын тэмдэглэгээ, чанарын гэрчилгээ, тохирлын тэмдгийг хууль бусаар ашигласан аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-150000, иргэнийг 15000-25000 төгрөгөөр торгож, хууль бусаар олсон орлогыг хураах;

е/хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүний болон хөдөлмөрийн нөхцөл, өдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаанд мөрдөхөөр тогтоосон заавал мөрдөх УСТ-ын үзүүлэлт, шаардлагыг зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-250000, иргэнийг 25000-50000 төгрөгөөр оргож, уг бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг хураах;

ж/зориулалтын бус түүхий эд, тоног төхөөрөмжөөр согтууруулах ундаа үйлдвэртэж, улсын стандартын үзүүлэлт шаардлага зөрчсөн, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй худалдсан аж ахуйн нэгж, байгууллагыг 75000-250000, иргэнийг 40000-50000 төгрөгөөр оргож, хууль бусаар олсон орлогыг хураах;

з/согтууруулах ундаанд шошгололт, хаяглалтын улсын стандартыг мөрдөөгүй, худалдах зорилгоор импортолсон согтууруулах ундаанд эрх бүхий байгууллагын зөхих зөвшөөрөл аваагүй аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-150000, иргэнийг 20000-50000 төгрөгөөр оргох;

и/улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч нь хяналт яалгалтаас зайлсхийсэн албан тушаалтныг 5000-10000 төгрөг, шаардлагатай гэж үзсэн баримт бичгийг танилцуулах, түр

хутацаагаар хүлээлгэн өгөхөөс зайлсхийсэн албан тушаалтныг 150С хүртэл төгрөгөөр торгох;

к/хяналт шалгалтын байгууллага, улсын байцаагчийн алба шаардлагыг эсэргүүцсэн, тогтоосон хутацаанд биелүүлээгүй, шаардлагын биелэлтийг гаргаж ирүүлээгүй албан тушаалтныг 5000-2500 төгрөг, хянан шалгах үйл ажиллагаанд саад учруулсан, гаргах дүнд нэлт, шийдвэрт нөлөөлөхийг оролдсон этгээдийг 35000 хүртэ төгрөг, хяналт шалгалтад холбогдолтой баримт бичгийг гарга өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзсан, гэмтээсэн, устгасан, хуурам баримт бичиг гаргаж өгсөн албан тушаалтныг 30000-50000 төгрөгөө тус тус торгуулах саналаа шүүгчид тавьж шийдвэрлүүлэх;

д/согтууруулах ундааны шошгыг хуурамчаар үйлдэх, хуу бусаар хэрэглэх, худалдах ажиллагаа үйлдсэн аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-200000, иргэнийг 10000-40000 төгрөгөөр торг асуудлыг шүүгчид тавьж шийдвэрлүүлэх.

Дөрөв.Бусад зүйл

15.Стандарт,чанарын улсын хяналтын алба, улсын байцаагчийн албан шаардлагыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалта холбогдох хүмүүс хутацаанд нь биелүүлж, хариуг албан ёсоор ө байх үүрэгтэй.

16.Байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, холбогд хүмүүс улсын байцаагчийн гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гз үзвэл гомдлоо уг шийдвэр гарснаас хойш 10 хоногийн дотор тухай шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргаж болно.

Уг гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хяна шийдвэрлэнэ. Энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүх гаргаж болно. Гомдол гаргах нь ноцтой зөрчлийг арилгахгүй бай үндэслэл болохгүй.

17.Улсын байцаагч үүрэгт ажлаа зохих ёсоор биелүүлдэггүй, хуу тогтоомж зөрчсөн бол түүнд холбогдох хууль тогтоомжид заасн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Засгийн газрын 1996 оны 57 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

ХЭМЖИЛЗҮЙН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.Хэмжилзүйн улсын хяналтын зорилт нь Монгол Улсын эмжээнд байгууллага, аж ахуйн нэгжийн харьяалал, өмчийн элбэрийг харгалзахгүйгээр хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай ууль тогтоомж, түүнийг үндэслэн эрх бүхий байгууллагаас нийтээр агаж мөрдөхөөр тогтоосон дүрэм, журмын биелэлтийг хангуулахад ршино.

2.Хэмжилзүйн улсын хяналтыг хэмжилзүйн улсын хяналтын лба, аймаг, нийслэлийн хэмжилзүйн хяналтын улсын байцаагчид эрэгжүүлнэ.

3.Хэмжилзүйн улсын хяналтын албаны дарга нь хэмжилзүйн хяналтын улсын ерөнхий байцаагч байна.Хэмжилзүйн хяналтын тсын ерөнхий байцаагчийг хэмжилзүйн асуудал эрхэлсэн сайд эмилж, чөлөөлөх бөгөөд улсын ерөнхий байцаагчийн эрхийг асгийн газар олгоно.

4.Хэмжилзүйн улсын хяналтын албаны улсын ахлах байцаагч, тсын байцаагчийг хэмжилзүйн хяналтын улсын ерөнхий ийцаагчийн санал болгосноор хэмжилзүйн асуудал эрхэлсэн сайд эмилж чөлөөлнө.

Аймаг, нийслэлд ажиллах хэмжилзүйн хяналтын улсын байцааг-ийг аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлөх бөгөөд тсын байцаагчийн эрхийг хэмжилзүйн асуудал эрхэлсэн сайд тгоно.

5.Ажил төрлийн онцлог байдлаас зарим яам, тусгай газарт хэм-илзүйн хяналтын улсын байцаагч ажиллуулж болно. Яам, тусгай зарт ажиллах улсын байцаагчийг сайд, дарга нар нь томилж, лөөлөх бөгөөд улсын байцаагчийн эрхийг хэмжилзүйн асуудал хэлсэн сайд олгоно.

6.Хэмжилзүйн хяналтын улсын байцаагчид нь хэмжилзүй, хэм-их хэрэгслийн баталгаажуулалтын асуудлаар мэргэшсэн байна.

7.Хэмжилзүйн улсын хяналтын алба, хэмжилзүйн хяналтын тсын байцаагчид нь үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох уль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон энэхүү дүрмийг ирдлага болгоно.

8.Хэмжилзүйн хяналтын улсын ерөнхий байцаагч, ахлах йцаагч, улсын байцаагч /энэ дүрэмд "Улсын байцаагч" гэх/

Засгийн газраас загварыг нь баталсан үнэмлэх, хувийн дугаар бүхнэ тэмдэг болон албан шаардлага, акт дүгнэлт, торгууль, шийтгэврийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

9.Аймаг, нийслэлд болон яам, газарт ажиллаж байгаа улсын байцаагчийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, ажлыг нь шалгах шалгалтын дүнг нэгтгэн дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлаар ава арга хэмжээний санал боловсруулж шийдвэртлүүлэхийг хэмжилзүйн улсын хяналтын алба хариуцан хэрэгжүүлнэ.

Хоёр.Хэмжилзүйн улсын хяналтын чиглэл:

10.Хэмжилзүйн улсын хяналтыг дор дурдсан чиглэлээ хэрэгжүүлнэ:

а/хэмжлийн нэгдмэл байдлыг хангахтай холбогдож гарсан хууль тогтоомж, хэмжилзүйн дүрэм, журам, худалдаа, үйлчилгээний хүрээнд хэмжил гүйцэтгэх аргачлалын мөрдөлт;

б/хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 7-гийн 2-заасан улсын баталгаажуулалтанд заавал хамрагдвал зохих хэмжих хэрэгслийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс үйлдвэртэсэн буюу импортолсон нөхцөлд тэдгээрийг загварын туршилтанд хамруулж улсын бүртгэлд бүртгүүлэн, загварын баталгаа олгосон эсэх;

в/хэмжих хэрэгслийг үйлдвэртэл, засвараас гарсны дара болон тэдгээрийг ашиглах, хадгалах явцад баталгаажуулалта хамруулсан эсэх;

г/улсын баталгаагүй хэмжүүр, хэмжих хэрэгслийг худалдаа үйлчилгээнд ашигласан, буслалд хэрэглүүлсэн болон худалдсан эсэх;

д/хэмжих хэрэгслийн улсын баталгааны хугацаа дууссан бололца, тэмдэг нь хөндөгдсөн буюу арилсан, улсын баталгааны гэрчилгээг үрэгдүүлсэн, хуурамчаар үйлдсэн, эвдэрсэн буюу буруу заалттай хэмжих хэрэгслийг ашигласан эсэх;

е/худалдаа, үйлчилгээний тооцоонд хэрэглэхийг хориглосон хэмжүүр, хэмжих хэрэгслээр үйл ажиллагаа явуулж байгаа эсэх;

ж/хэмжлийн нэгж нь хэрэглэхийг зөвшөөрсөн нэгжтэй тохир байгаа эсэх;

з/хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, техникийн бэлэн байдал болон хэмжих хэрэгслийн ашиглалтын нөхцөл нь баталса загварын шаардлагад тохирч буй эсэх;

и/хэмжих хэрэгслийг баталгаажуулахад ашиглаж байгаа эталоны техникийн бэлэн байдал;

к/стандартчилсан загвар, түүний техникийн болон хэрэглээний байдал;

л/савласан болон боосон бүтээгдэхүүний хүнд, эхлэхүүн зэрэг

тоон үзүүлт нь боодол дээр тэмдэглэсэн хэмжээ, зөвшөөрөгдөх хэлбэлзлийн хязгаартай тохирч байгаа эсэх.

Гурав.Хэмжилзүйн хяналтын улсын байцаагчийн үүрэг, эрх

11.Улсын байцаагч нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а/энэ дүрмийн 10 дугаар зүйлд заасан чиглэлийн дагуу хэмжилзүйн улсын хяналтыг зохион байгуулж хэрэгжүүлэх;

б/хөндлөнгийн нөлөөнд үл автан, албан үүргээ шударгаар гүйцэтгэх, аж ахуйн нэгж, байгууллагын болон иргэний хувийн ашиг сонирхлыг төлөөлж, тэдгээрт ашигтай, давуу тал бий болгосон шийдвэр гаргахгүйгээр хяналт шалгалтыг бүрэн гүйцэд хийх;

в/хийсэн шалгалт, гаргасан дүгнэлт, тавьсан акт, торгууль, албан шаардлагын үнэн зөвийг бүрэн хариуцах;

г/хяналт, шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

12.Улсын байцаагч нь дор дурдсан эрх эдэлнэ:

а/хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, таслан зогсоох талаар аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, холбогдох хүмүүст шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах;

б/холбогдох байгууллагатай нь тохиролцсоноор зохих мэргэжлийн хүмүүсийг хяналт, шалгалтын ажилд татан оролцуулах, шаардлагатай асуудлыг магадлах зорилгоор өндөр нарийвчлал бүхий тоног төхөөрөмжтэй байгууллагын хэмжүүрийн итгэмжлэгдсэн лабораториор дүгнэлт, харьцуулалт хийлгэх;

в/шалгалтанд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, баримт материалыг тухайн аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулж авах;

г/улсын баталгаажуулалтад хамрагдаагүй хэмжих хэрэгслийг тооцооны зориулалтаар ашиглахыг хориглох;

д/шаардлагатай үед өмчийн хэлбэрийг харгалзахгүйгээр аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээний байранд үхтэг, шалгалт хийх;

е/баталгаагүй, эсхүл загвар нь батлагдаагүй буюу баталсан загвартаа тохирохгүй байгаа хэмжих хэрэгсэл ашиглах, худалдах, бусдад хэрэглүүлэхийг хориглох;

ж/баталгаажуулалтын хугацаа дууссан буюу буруу заалттай хэмжих хэрэгслийн баталганы лац, тэмдгийг хүчингүй болгож гэрчилгээг хураах;

з/аж ахуйн нэгж, байгууллага, холбогдох хүмүүс хэмжих

хэрэгслийг үйлдвэрлэх, засварлах, худалдах, бусдад хэрэглүүлэх журмыг зөрчсөн бол зөрчлийг бүрэн арилгах хүртэл зөвшөөрлийг хүчингүй болгохыг шаардах;

и/хэмжлийн зөрчил гаргаж нийгэм, хэрэглэгчийг хохироосон байгууллага, аж ахуйн нэгж, холбогдох хүмүүсийн хууль бус ажиллагааны талаар олон нийтэд зарлан мэдээлж, сэрэмжлүүлэг хийх;

к/хэмжих хэрэгслийн үйлдвэрлэл, засвар, тохируулгын ажлыг хууль бусаар үйлдэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг хохироосон асуудлыг холбогдох баримтыг бүрдүүлэн хуулийн байгууллагад шилжүүлэх.

13.Хэмжилзүйн хяналтын улсын байцаагч нь хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн, тавьсан шаардлагыг биелүүлээгүй гэм буруутай этгээдэд Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, Захиргааны хариуцлагын, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулиуд болон холбогдох бусад хуулийн заалтыг үндэслэн дор дурдсан захиргааны хариуцлага хүлээлгэнэ:

а/бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил, үйлчилгээ эрхлэхдээ Монгол Улсад хэрэглэхийг зөвшөөрснөөс өөр хэмжлийн нэгжийг хэрэглэсэн, хэмжлийн нэгжийн нэр, тэмдэглэгээ болон тэдгээрийг бичих, хэрэглэх журмыг зөрчсөн бол хууль бусаар олсон орлогыг хурааж, зөрчил гаргасан аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр торгох;

б/хэмжилзүйн улсын байцаагч, хэмжүүрийн улсын шалгагчаас хяналт шалгалт явуулахад шаардагдах мэдээ материалыг буруу гаргаж өгсөн, хэмжилзүйн улсын байцаагчаас тавьсан шаардлага, хугацаатай үүргийг биелүүлээгүй аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000, албан тушаалтныг 10000-20000, иргэнийг 5000-10000 төгрөгөөр торгох;

в/баталсан загвар, стандарт, техникийн болон ашиглалтын шаардлага хангаагүй хэмжих хэрэгсэл ашигласан, хэмжих хэрэгслийн шалгалт,тохируулга хийхдээ баталгаагүй эталоныг ашигласан бол хууль бусаар олсон орлогыг хурааж, зөрчил гаргасан аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-150000, иргэнийг 5000-15000 төгрөгөөр торгох;

г/хэмжлийг УСТ, аргачлалын дагуу хийгээгүй, шаардагдах нарийвчлал, хэмжлийн хязгаарт тохироогүй хэмжих хэрэгсэл ашигласан, загварын туршилт хийлгэж баталгаажуулаагүй импортын хэмжих хэрэгсэл ашигласан, улсын баталгаагүй хэмжих хэрэгслийг худалдсан болон бусдад хэрэглүүлсэн, ахуйн зориулалттай хэмжих хэрэгслийг худалдаа, үйлчилгээнд хэрэглэсэн зэрэг зөрчил гаргасан аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-200000, иргэнийг 10000-20000

төгрөгөөр торгож, хууль бусаар олсон орлогыг хураах;

д/савласан, боосон бүтээгдэхүүний тоон хэмжээ, хэлбэлзэх утгыг тэмдэглээгүй буюу буруу тэмдэглэсэн, эсхүл савласан, боосон жингийн тоон хэмжээ нь хаяг, шошгон дээр бичигдсэн хэмжээ-гэйтээ тохирохгүй байвал зөрчил гаргасан аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-200000, иргэнийг 10000-20000 төгрөгөөр торгож, хууль бусаар олсон орлогыг хураах;

е/хэмжих хэрэгслийн үйлдвэрлэл, засвар, худалдаа, шалгалт, гохируулгын ажил үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг хэмжилзүйн төв байгууллагаас авалгүй ажил үйлчилгээг эрхэлсэн аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгож, хууль бусаар олсон орлогыг хураах;

ж/улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч нь хяналт, шалгалтаас зайлсхийсэн албан тушаалтныг 5000-10000 төгрөг, шаардлагатай эж үзсэн баримт бичгийг танилцуулах, түр хугацаагаар хүлээлгэн гэхөөс зайлсхийсэн албан тушаалтныг 15000 хүртэл төгрөгөөр торгох;

з/хяналт, шалгалтын байгууллага, улсын байцаагчийн албан тушаалыг эсэргүүцсэн, тогтоосон хугацаанд биелүүлээгүй, шаардлагын биелэлтийг гаргаж ирүүлээгүй албан тушаалтныг 5000-25000 төгрөг, хянан шалгах үйл ажиллагаанд саад учруулсан, гаргах дүгээлт, шийдвэрт нөлөөлөхийг оролдсон этгээдийг 35000 хүртэл төгрөг, хяналт шалгалтад холбогдолтой баримт бичгийг гаргаж гэхөөс үндэслэлгүйгээр татгалзсан, гэмтээсэн, устгасан, хуурамч баримт бичиг гаргаж өгсөн албан тушаалтныг 30000-50000 төгрөгөөр ус тус торгуулах саналаа шүүгчид тавьж шийдвэрлүүлэх.

Дөрөв.Бусад зүйл

14.Хэмжилзүйн улсын хяналтын алба, улсын байцаагчийн албан тушаалыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, холбогдох үмүүс хугацаанд нь биелүүлж, хариуг албан ёсоор өгч байх үрэгтэй.

15.Байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, холбогдох үмүүс улсын байцаагчийн гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гэж зөвл гомдлоо уг шийдвэр гаргаснаас хойш 10 хоногийн дотор ухайн шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргаж болно.

Уг гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ.Энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд эргэж болно.Гомдол гаргах нь ноцтой зөрчлийг арилгахгүй байх ндэслэл болохгүй.

16. Улсын байцаагч үүрэгт ажлаа зохих ёсоор биелүүлээгүй, хуул тогтоомж зөрчсөн бол түүнд холбогдох хууль тогтоомжид заасн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1996 оны 3 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 62

Улаанбаатар
хот

Журам батлах туха

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Улсын хэрэгцээнд гэрээгээр кино хийлгэх тухай журам"-ыг 1 дүгээр, "Киног дэлгэцнээ гаргах зөвшөөрөл олгох тухай журам"-ыг 2 дугаар, "Гадаадын байгууллага, иргэдэд кино зург авах зөвшөөрөл олгох тухай журам"-ыг 3 дугаар хавсралтын ёсоос тус тус баталсугай.

2. Энэ тогтоолын хавсралтаар батлагдсан журмуудыг хэрэгжүүлэх тэй холбогдсон арга хэмжээ авч ажиллахыг Соёлын яам (Н.ЭНХБАЯР), Сангийн яам (Э.БЯМБАЖАВ)-д даалгасугай.

3. Кино хийх, зөвшөөрөл олгох үйл ажиллагааг журамла зохицуулж байгаатай холбогдуулан "Журам, жагсаалт батлах тухай Засгийн газрын 1991 оны 260 дугаар тогтоолоор баталса "Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд зөвшөөрөл олгох тухай журам"-ы хавсралт "Аж ахуйн нэгжээс зөвшөөрөлтэйгээр эрхлэн гүйцэтгэ болох үйлдвэрлэл, үйлчилгээний жагсаалт"-д дор дурдсан нэмэлтий оруулсугай:

29. Кино, дүрс бичлэгээр үйлчлэх үйл ажиллагаа эрхлэх

-Соёлын яам

30. Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын байгууллага, иргэдээс кино зураг авах, дүрс бичлэг хийх үйл ажиллагаа явуулах

-Соёлын яам

1. Дуу бичлэгийн үйлчилгээ эрхлэх

-Аймаг, нийслэлийн
Засаг даргын Тамгын
газар, түүний эрх
олгосон байгууллага

Монгол Улсын Ерөнхий сайд

П.ЖАСРАЙ

Соёлын сайд

Н.ЭНХБАЯР

Сангийн сайд

Э.БЯМБАЖАВ

Засгийн газрын 1996 оны 62 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

УЛСЫН ХЭРЭГЦЭЭНД ГЭРЭЭГЭЭР КИНО ХИЙЛГЭХ ТУХАЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Төрөөс кино урлагийн талаар баримтлах бодлого, чиглэлийн гэрээнд үзэгчдийн оюун санааны эрэлт хэрэгцээнд зориулан ийлшгүй шаардлагатай уран сайхны болон баримтат киног улсын хэрэгцээнд гэрээгээр хийлгэхэд энэхүү журмыг мөрдөнө.

2. Улс, нийгмийн зайлшгүй хэрэгцээ шаардлагыг судлан үзэж, хайн жилд болох түүхэн тэмдэглэлт үйл явдал болон төр, засгийн яга хэмжээ, тэдгээрийг кино уран бүтээлд тусган харуулах тухай мбогдох байгууллага, газруудын санал, захиалгыг урьдчилан авч тсын хэрэгцээнд гэрээгээр хийх киноны бүтээлийн сэдэв, мөвлөгөө, урьдчилсан төсвийг гаргасны үндсэн дээр энэ риулалтаар шаардагдах зардлыг жил бүрийн төвлөрсөн төсөвт цгуулах асуудлыг соёл, урлагийн асуудал эрхэлсэн төрийн хиргааны төв байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

Хоёр. Төсөл сонгож шалгаруулах, санхүүжүүлэх

3. Батлагдсан сэдэв, төлөвлөгөө, төсвийн хүрээнд улсын хэрэг-
цээнд гэрээгээр хийх уран сайхны, баримтат киноны зохиол болон
гно найруулагч, студийг сонгож шалгаруулах ажлыг Монгол Улсын

соёл, урлагийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон киноны уран бүтээлийн мэргэжлийн комисс (цаашид "мэргэжлийн комисс" гэнэ) гүйцэтгэнэ.

4. Мэргэжлийн комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг Монгол Улсын соёл, урлагийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж мөрдүүлнэ.

5. Захиалгат киног бүтээхээр шалгарсан кино студи нь кино хийх найруулагч болон бусад уран бүтээлчидтэй гэрээ хийж, тэдний томилж ажиллуулах шийдвэр гаргана.

6. Соёл, урлаг хөгжүүлэх сан (захиалагч) кино хийх студ (гүйцэтгэгч)-тэй гэрээ байгуулж, кино хийх зардлыг санхүүжүүлнэ.

7. Улсын хэрэгцээнд кино хийх студид эхний ээлжин үйлдвэртэлийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний урьдчилгаа олгох бөгөөд кино хийх ажлын явцад зардлын 20 хүртэл хувийг нэмж санхүүжүүлж болно. Харин үлдэх хэсгийг кино үйлдвэрлэл дууссаны дараа гэрээний дагуу эцсийн тооцоо хийж санхүүжүүлнэ.

8. Уран бүтээлчдийн шагналын 60 хувийг урьдчилгаа болгс олгож, үлдсэн хэсгийг олгох, эсэх асуудлыг захиалагч киног хүлээ авсны дараа уг киноны уран сайхны түвшингийн зэрэглэл: хамааруулан шийдвэрлэнэ. Уг шагналыг захиалагч олгохгүй тохиолдолд уран бүтээлчдийн (хэрвээ тухайн уран бүтээлч буруугүй бол шагналын үлдэх хэсгийг кино хийх зөвшөөрөл авсан студи хариуцан олгоно.

9. Захиалгаар кино хийх зардлыг улсын төсвөөс жил бүр Соёл, урлаг хөгжүүлэх санд хуваарилж байна. Ийнхүү хуваарилагдсан хөрөнгийг тухайн уран бүтээлийг хийх талаар энэ журмын 6, 7 дугаар зүйлд заасны дагуу байгуулсан гэрээг үндэслэн санхүүжүүлнэ.

10. Улсын захиалгаар баримтаг кино, кино мэдээ хийж байгаа кино сурвалжлагч нь улс, олон нийтийн болон бусад байгуулалтуудад нэвтрэх эрх эдэлнэ. Тусгай нэвтрэх үнэмлэхийг Монгол Улсын соёл, урлагийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн кино сурвалжлагчдад олгоно.

Гурав. Киног хүлээж авах

11. Киног нэг плёнк дээр буулгахаас өмнө мэргэжлийн хүмүүс үзүүлж зөвлөлгөө авах урьдчилсан үзлэгийг кино студи хариуцан зохион байгуулна.

12. Кино үйлдвэрлэл бүрэн дууссаны дараа уг киноны уран сайхны түвшинг Монгол Улсын соёл, урлагийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон уран сайхны

өвлөл тогтооно. Киноны уран сайхны түвшинг дараахь 3 зэрэглэлээр тогтооно:

а/1 дүгээр зэрэглэл:

-урлаг уран сайхан, ур чадварын хувьд мэргэжлийн өндөр түвшинд хийгдсэн;

-захиалагчийн хэрэгцээг бүрэн хангасан;

-далхийн кино урлагийн түвшинд хүрэхүйц болсон;

-уран сайхны зөвлөлөөс "Онц" гэсэн үнэлгээ авсан.

б/2 дугаар зэрэглэл:

-урлаг, уран сайхан, ур чадварын хувьд мэргэжлийн түвшинд айдгдсэн;

-захиалагчийн хэрэгцээг хангасан;

-уран сайхны зөвлөлөөс "Сайн"-аас доошгүй үнэлгээ авсан.

в/3 дугаар зэрэглэл:

-урлаг уран сайхны хувьд жигд биш, мэргэжлийн дунд түвшинд хийгдсэн;

-захиалагчийн хэрэгцээг бүрэн хангаагүй боловч уг киног үзсэн авахыг зөвшөөрсөн;

-уран сайхны зөвлөлөөс "Дунд"-аас доошгүй үнэлгээ авсан.

Хийсэн кино нь 1 дүгээр зэрэглэлийн түвшинг хангавал уран гээлчдэд олгох уран бүтээлийн шагналын үлдсэн хэсгийг 100 хувь, дугаар зэрэглэлийн түвшинг хангавал шагналын үлдсэн хэсгийн 50 вийг олгоно. Хэрэв уран сайхны зөвлөл уг киног 3 дугаар зэрэглэлийн түвшинд хийгдсэн байна гэж үнэлбэл шагналын үлдсэн сгийг олгохгүй.

13.Бэлэн болсон киног дэлгэцнээ гаргах, дотоод гадаадын кино-а байгууллагад худалдах асуудлыг киног дэлгэцнээ гаргах зөвшөө-сөл олгох журмын дагуу шийдвэрлэнэ.

14.Улсын хэрэгцээнд гэрээгээр хийсэн киног дууссаны дараа 1 хоногийн дотор захиалагч, гүйцэтгэгч нар байгуулсан гэрээгээ гнэж, санхүүгийн тооцоог бүрэн дуусгана.

15.Кино студи (гүйцэтгэгч) нь архивт хадгалуулах зорилгоор киноны эх материал негатив, дууны фонограмм, киноны товч йлбар, монтажийн хуудас, найруулагчийн төлөвлөгөө позитивын г хувийг захиалагчид хүлээлгэн өгнө.

16.Улсын хэрэгцээнд гэрээгээр кино хийх тухай журмыг зөрчиж ихүүжилтийн хөрөнгийг өөр зориулалтаар ашиглах, гэрээгээр сан үүргээ зөрчих, биелүүлэхгүй байх гэх мэт) улсад болон уран гээлчдэд учруулсан хохирлыг холбогдох кино студиэр талүүлж ашид уг кино студид улсын захиалгаар кино хийх зөвшөөрөл гохгүй байж болно.

17. Кино хийхтэй холбогдсон гэрээ, хөрөнгө санхүүгийн асуудлаар захиалагч, гүйцэтгэгч байгууллагын хооронд маргаан үүсвэл у асуудлыг зохих дээд шатны байгууллага, эсвэл шүүхээр шийдвэрлүүлнэ.

Засгийн газрын 1996 оны 62 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

КИНОГ ДЭЛГЭЦНЭЭ ГАРГАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТУХАЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монголын киноны уран бүтээлчдийн туурвин нийтэд дэлгэцнээ гаргах уран сайхны болон баримтат, зурмал (мультифильм) хүүхэддэйн киноны нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх, дүн шинжилгээ хийх, уран сайхны түвшинг үнэлэх, үзэгчид ялангуяа хүүхэд залуучуудын оюуны хэрэгцээ, танин мэдэхүйн эрэлт хэрэгцээ хангахад тус дэмжлэг үзүүлж кино үзвэр, үйлчилгээний ажлы зохицуулан зохион байгуулахад энэхүү журмын зорилго оршино.

2. Энэхүү журмын дагуу зөвшөөрөл авсан кино олон улсын наадам үзлэгт оролцох хийгээд гадаад, дотоодын зах зээлд борлогдо эрх эдэлнэ.

3. Шинээр хийсэн Монголын уран сайхны болон баримтат зурмал, хүүхэддэйн кино, мөн түүнчлэн гадаад орны дэлгэцийн болон дүрс бичлэгийн киног тус улсын нутаг дэвсгэрт дэлгэцнээ гаргаж нийтэд үзүүлэх зөвшөөрөл (цаашид "зөвшөөрөл" гэнэ олгоход энэ журмыг мөрдөнө.

4. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр кино хийх, үйлдвэрлэх нийтэд зориулан үзвэр, үйлчилгээ явуулах ажил эрхэлж байга байгууллага, аж ахуйн нэгж, иргэн энэ журмыг дагаж мөрдөнө.

5. Энэ журмын 3-т заасан зөвшөөрлийг Монгол Улсын соёл урлагийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тушаалаар томилогдсон орон тооны бус зөвлөл (цаашид "зөвлөл гэнэ) олгоно.

Зөвлөлийн бүрэлдэхүүнд соёл, урлагийн нэрт зүтгэлтэн, судлаачид төрөл бүрийн мэргэжлийн шинжээчид, уран бүтээлчид, кин үзвэрийн байгууллагын ажилтан, хууль эрх зүйн мэргэжилтэн, хү амын янз бүрийн хэсгийн төлөөлөгчдийг оруулна.

6. Энэ журам нь байгаль орчныг хамгаалах, шинэжлэх ухаан танин мэдэхүй, сурталчилгааны зориулалттай баримтат кино болон

уувь хүний хэрэгцээнд худалдан авсан видео кино, телевизийн нэвтрүүлэг хийх эрх бүхий байгууллагын нэвтрүүлэгт зориулсан кинонд үл хамаарна.

7. Телевизээр нийтэд зориулан үзүүлэх уран сайхны кинонд зөвшөөрөл олгох асуудлыг Радио, телевизийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас жичид нь тогтоож мөрдүүлнэ.

**Хоёр. Зөвшөөрөл олгох үндэслэл, хураамж,
үйтгэлгээний хөлс**

8. Энэ журмын дагуу шинээр хийсэн Монголын дэлгэцийн болон дүрс бичлэгийн (видео) киног дэлгэцнээ гаргах зөвшөөрөл авах айгууллага, хүмүүс дор дурдсан баримт бичгийг бүрдүүлж зөвлөлд ирүүлнэ:

а/киног дэлгэцнээ гаргах зөвшөөрөл хүссэн албан бичиг буюу өргөдөл;

б/киноны товч танилцуулга (киноны нэр, кино хийсэн болон вээн тэтгэсэн байгууллага, аж ахуйн нэгжийн нэр, зардлын эмжээ, үргэлжлэх хугацаа, стандарт хэмжээ, хийсэн хугацаа хэлсэн, дууссан гэх мэт);

в/киноны монтажийн хуудас;

г/зөвшөөрөл олгохоор үзэх киноны хяналтын хувь;

д/зохиогчийн эрхийн хуулийн дагуу уг киног эзэмших эрхийг отлох гэрчилгээ.

9. Гадаад орноос худалдан авсан дэлгэцийн болон дүрс бичлэгийн киног дэлгэцнээ гаргах зөвшөөрөл олгоход дор дурдсан баримт бичгийг бүрдүүлж зөвлөлд ирүүлнэ:

а/киног дэлгэцнээ гаргах зөвшөөрөл олгохыг хүссэн албан бичиг буюу, өргөдөл;

б/киноны товч танилцуулга (киноны нэр, бүтээсэн улс, эрэл, анги бүлгийн тоо, стандарт хэмжээ, ямар хэлнээ хийгдсэн элэх, өнгөт, хар цагаан гэх мэт);

в/тухайн киног худалдан авсан улсын эрх бүхий байгууллагын тухай танилцуулга, хаяг;

г/уг киног худалдан авсан тухай төлбөрийн баримт;

д/зөвшөөрөл олгоход үзүүлэх киноны хувь.

10. Киног гадаад оронд худалдах, солилцоход дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

а/киног худалдах, солилцох, хилээр гаргах зөвшөөрөл хүссэн албан бичиг;

б/уг киног дэлгэцнээ гаргах зөвшөөрлийн хуулбар;

в/киног худалдах, солилцох тухай киноны болон эрх бүхий

байгууллагатай байгуулсан гэрээний хуулбар;

г/киног захиран зарцуулах эрх бүхий эзэмшигчдийн зөвшөрөл, зохиогчийн эрхийг эзэмшигчийн гэрчилгээ.

11.Зөвлөл нь гишүүдийнхээ 75-аас доошгүй хувийн бүрэлдэхүү тэйгээр киног үзэж, нууцаар санал хураан олонхийн санал нийтэд үзүүлэх зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

12.Хуял тачаал (эротик), аймшгийн киног тусгай зэрэглэл хамааруулж, түүнийг зөвхөн зөвшөөрөгдсөн тодорхой газар гарга үзүүлэхээр зөвшөөрөл олгоно.

13.Улс, үндэстэн ястны түүхийг мушгин гуйвуулсан, хооронд дайсагнах үзэл санааг агуулж дэвэргэсэн, хүчирхийлэл, сад самууныг сурталчилсан, гэмт хэргийн үйлдлийн аргыг нарийвчлал үзүүлсэн киног нийтэд зориулан дэлгэцнээ гаргах зөвшөөрөл олгохгүй.

14.Энэ журмын 8, 9, 10-д заасан баримт бичгийг бүрдүүлсэн киног дэлгэцнээ гаргах, худалдах зөвшөөрөл авахыг хүссэ байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг зөвлөл хүлэ авснаас хойш 14 хоногт багтаан хянан шийдвэрлэж зохих хари өгнө.

15.Киног дэлгэцнээ гаргах зөвшөөрөл олгохдоо хууль тогтоомж заасны дагуу хураамж, үйлчилгээний хөлс авна.

Гурав.Хориглох зүйл

16.Киног дэлгэцнээ гаргах зөвшөөрлийг хуулбарлах, бусд шилжүүлэх болон өөр хэлбэрээр ашиглахыг хориглоно.

17.Зөвлөлөөс зөвшөөрөл аваагүй кино Монгол Улсын нут дэвсгэрт дэлгэцнээ гаргахыг хориглоно.

Дөрөв.Хариуцлага

18.Дэлгэцнээ гаргах зөвшөөрөлгүй киногоор үйлчилсэн, э бүхий байгууллагын шийдвэрээр хориглосон газар кино үйлчилг явуулсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд "Захиргаан хариуцлагын тухай" Монгол Улсын хуульд заасны дагуу хариуцла хүлээлгэнэ.

19.Киног дэлгэцнээ гаргах зөвшөөрөл олгох журмын хэрэгжилт тавих олон нийтийн хяналт, оролцоог идэвхжүүлэх зорилгоор зөх зөвшөөрөлгүй кино, дүрс бичлэг гаргаж байгаа тухай бодитой үн зөв мэдээлэл өгч, тэр нь нотлогдсон тохиолдолд гэм буруут этгээдэд энэ журмын 18-д заасныг үндэслэн торгууль ногдуу олсон орлогын хэмжээтэй уялдуулан мэдээлэл өгсөн байгуулла

к ахуйн нэгж, иргэдэд соёл, урлаг хөгжүүлэх сангаас зохих дамшуулал олгоно.

20. Энэ журмыг удаа дараалан зөрчсөн байгууллага, аж ахуйн нэгж, иргэний урьд нь зөвшөөрөл авсан бол түүнийг нь хүчингүй элгэж, зөвшөөрөл дахин олгохгүй байж болно.

Засгийн газрын 1996 оны 62 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт

ГАДААДЫН БАЙГУУЛЛАГА, ИРГЭДЭД КИНО ЗУРАГ АВАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Тус улсын нутаг дэвсгэрт гадаадын байгууллага, иргэдээс бүх рлийн мэргэжлийн кино зураг (уран сайхны, баримтат, телеви- йн, дүрс бичлэгийн кино) авах (цаашид "кино зураг авах" гэнэ) л ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

2. Гадаадын байгууллага, иргэд Монгол Улсын нутаг дэвсгэрт нгаараа буюу монголын байгууллага, иргэдтэй хамтран кино зураг ах, хамтарсан кино хийхэд Монгол Улсын соёл, урлагийн асуудал хэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид "эрх бүхий йгууллага" гэнэ)-аас зөвшөөрөл олгоно.

Хоёр. Зөвшөөрөл олгох үндэслэл, үйлчилгээний төлбөр

3. Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авах гадаадын йгууллага, иргэд хүсэлтээ эрх бүхий байгууллагад урьдчилан үүлнэ.

4. Гадаадын байгууллага, иргэдээс Монгол Улсын нутаг дэвсгэрт но зураг авах зөвшөөрөл авахын тулд дор дурдсан баримт бичгийг мдүүлнэ:

- а/ зөвшөөрөл олгохыг хүссэн албан бичиг буюу өргөдөл;
- б/ хамтран ажиллах болон үйлчилгээ үзүүлэх байгууллага, аж йн нэгж, иргэнтэй байгуулсан гэрээний хуулбар;
- в/ зураг авахад хэрэглэх техник хэрэгслийн жагсаалт;
- г/ авах кино зургийн тухай товч танилцуулга;
- д/ кино зураг авах Монголын болон гадаадын киноны байгуул- а, иргэдийн албан ёсны хаяг;

е/кино зураг авах хугацаанд гадаадын уран бүтээлчдийг Монгол Улсад байрлах хаяг.

5.Зөвшөөрөл олгохыг хүссэн дээрх баримт бичгийг эрх бүх байгууллага хүлээн авснаас хойш 1 сарын дотор шийдвэрлэж хар өгнө.

6.Эрх бүхий байгууллага дор дурдсан зүйлийг кинонд тусг харуулахаар байвал кино зураг авах, хамтран кино бүтээх зөвшөөр олгохоос татгалзаж болно:

а/улс, үндэстний түүхийг санаатайгаар мушгин гуйвуулс тэдгээрийн хооронд үл итгэх, дайсагнах уур амьсгалыг бий болгох чиглэсэн;

б/дайн, хүчирхийлэл, садар самууныг сурталчлан харуулс кино зураг авах;

в/гэмт хэргийн үйлдлийн аргыг кино зурагт нарийвчл үзүүлэх;

г/Монгол Улсын болон манай иргэдийн нууцыг задруул хандлагатай;

д/хүний эрхийг зөрчсөн, хувь хүнийг гүтгэсэн, эрх ашгийг хохироохоор бол.

7.Тус улсын нутаг дэвсгэр дээр кино зураг авах зөвшөөр олгохдоо хууль тогтоомжид заасны дагуу хураамж, үйлчилгээн хөлс авна.

8.Монгол Улсын улс төрийн асуудлаар сурвалжлага хи телевизийн сурвалжлагад Гадаад харилцааны яамны, хүмүүнлэги туслалцаа үзүүлэх, байгаль орчныг хамгаалах, шинжлэх ухаан тан мэдэхүйн сургалтад зориулсан кино хийх зөвшөөрөл олгох холбогдох яам, газрын санал, тодорхойлолтыг үндэслэн эрх бүх байгууллага зөвшөөрөл олгоно.

9.Нэг удаа олгох зөвшөөрөл нь тухайн киног хийх хугацаа хүчин төгөлдөр байна.

10.Эрх бүхий байгууллага нь гадаадын байгууллага, иргэдэд ки зураг авах зөвшөөрөл олгосон тухайгаа холбогдох яам, тусгай газ аймаг, нийслэл, сумын Засаг даргын Тамгын газарт албан ёсо мэдэгдэнэ.

11.Кино зураг авах хураамж, үйлчилгээний хөлс төлсөн баримт 3 хувь үйлдэж нэгдүгээр хувийг киноны зураг авах зөвшөөрөл авс байгууллага (иргэн)-д, хоёрдугаар хувийг гаалийн байгууллагад ө гуравдугаар хувь нь зөвшөөрөл олгосон байгууллагад үлдэнэ.

Энэхүү баримт бичиг нь гадаадын байгууллага, иргэдээс Монг Улсын нутаг дэвсгэрт кино зураг авахаар авчирсан кино хал киноны тоног төхөөрөмж, бусад материалыг улсын хилээр оруул гаргахад үндэслэл болно.

12. Кино зураг авалтын дунд үед угаалгах негатив, зураг авалтын киллагаа дууссаны дараа авч явах үлдсэн негативаа хилээр эвтрүүлэх зөвшөөрлийн дагалдах хуудсыг кино авах зөвшөөрөл згосон байгууллагаас гадаадын байгууллага, иргэдэд олгоно. агалдах хуудсанд авсан кино зургийн стандарт хэмжээ, плёнкны эрэл, улсын хилээр гарах боомт, тээврийн хэрэгсэл, хутацаа, авч ях албан тушаалтанг тодорхойлж баталгаажуулсан байна.

Гурав. Хориглох зүйл

13. Гадаадын байгууллага, иргэд нь кино зураг авах зөвшөөрлийг эр зориулалтаар ашиглахыг хориглоно.

Дөрөв. Хариуцлага, хяналт

14. Энэ журмын хэрэгжилтэд соёл, урлагийн асуудал эрхэлсэн рийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг ргын Тамгын газар хяналт тавина.

15. Кино зураг авах зөвшөөрөл бүхий этгээд Монгол Улсын uly, тогтоомжид харш үйл ажиллагаа явуулбал эрх бүхий йгууллага уг зөвшөөрлийг хүчингүй болгоно. Энэ тохиолдолд раамж, үйлчилгээний хөлсийг буцааж олгохгүй.

16. Кино зураг авах зөвшөөрөл авсан байгууллага, иргэн энэ /рмыг зөрчиж байна гэж үзвэл Монгол Улсын хууль хяналтын йгууллагуудын оролцоотойгоор гарсан зөрчлийг илрүүлэн арилгах га хэмжээг авна.

17. Зөвшөөрлийг хуурамчаар үйлдсэн буюу бусдад шилжүүлэн илгасан, энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Монгол Улсын иргааны хариуцлагын тухай хуульд заасан хариуцлагыг тээлгэнэ.

18. Зөвшөөрөлгүй кино зураг авсан тохиолдолд холбогдох этгээ- д зохих хууль тогтоомжийн дагуу торгууль ногдуулах бөгөөд уг но зургийн материалыг улсын хилээр гаргахгүй.

19. Энэ журмын хэрэгжилтэд олон нийтийн зүгээс тавих хяналт, олцоог идэвхжүүлэх зорилгоор журам зөрчсөн тухай бодитой, эн зөв мэдээлэл ирүүлсэн байгууллага, иргэдэд зохих урамшлыг ёл, урлаг хөгжүүлэх сангаас олгоно.

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч	Л. Цог
Нарийн бичгийн дарга	Сан. Жаргалсайхан
Гишүүд	Б. Цэндлоо Ч. Бавуу Б. Ганбат Б. Янжинлхам
Техник редактор	С. Итгэлт
Уншиж хянасан	Сан. Жаргалсайхан Б. Янжинлхам

Үйлдвэрт шилжүүлсэн 1996 оны 10-р сарын 4-нд.
Өрөлтөд 1996 оны 10-р сарын 7-нд. Хэвлэлтэд
1996 оны 10-р сарын 25-нд. Хэвлэлийн хуудас 5,25
Хэвлэсэн тоо 4100.

Манай хаяг: Улаанбаатар-12
Төрийн ордон. Утас 322838

Төр, засгийн Үйлчилгээ аж ахуйг
эрхлэх газрын харьяа
хэвлэх үйлдвэр